

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ТУХАЙ /шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хадгаламж, зээлийн хоршооны эрх зүйн үндсийг тодорхойлж, хадгаламж, зээлийн хоршоог үүсгэн байгуулах, тусгай зөвшөөрөл олгох, түүнийг хүчингүй болгох, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчмыг тогтоох, хяналт тавих, албадлагын арга хэмжээ авах, татан буулгах болон Төв хадгаламж, зээлийн хоршоо (цаашид “Төв ХЗХ” гэх), тогтворжилтын сан, хадгаламж хамгааллын үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль тогтоомж

2.1.Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол тухайн олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэхээс бусад хоршооны үйл ажиллагааг холбогдох хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зарчим

4.1.Хадгаламж, зээлийн хоршоо үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална:

- 4.1.1.сайн дурын гишүүнчлэлтэй байх;
- 4.1.2.гишүүдийн ардчилсан удирдлага, хамтын хяналттай, ил тод, нээлттэй байх;
- 4.1.3.гишүүдийн эдийн засгийн тэгш оролцоог хангаж, шударга хуваарилалт хийх;
- 4.1.4.хараат бус бие даасан байх;
- 4.1.5.гишүүд, ажилтныг сургалт, мэдээллээр хангах;
- 4.1.6.нийгмийн болон гишүүдийнхээ нийтлэг эрх ашгийн төлөө санаа тавих;
- 4.1.7.ялгаварлан гадуурхахгүй байх;
- 4.1.8.санхүүгийн тогтвортой байдлыг хангах;
- 4.1.9.бусад хадгаламж, зээлийн хоршоотой хамтран ажиллахыг эрэлхийлэх.

5 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1.“Хадгаламж, зээлийн хоршоо” гэж гишүүдийнхээ эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор гишүүддээ санхүүгийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үзүүлэх ардчилсан удирдлага, хамтын хяналт бүхий ашгийн төлөө бус хуулийн этгээдийг;

5.1.2.“Гишүүний хувь хөрөнгө” гэж хадгаламж, зээлийн хоршоонд гишүүнээр элсэхэд оруулах хоршооны дүрмээр тогтоосон, ижил хэмжээтэй, буцааж олгогдохгүй мөнгөн хөрөнгийг;

5.1.3. “Хоршоологчдын өмч” гэж нөөцийн сан, бусад сангууд, хандив, тусламж болон хуримтлагдсан орлого /алдагдал/-ын нийлбэрийг;

5.1.4. “Өөрийн хөрөнгө” гэж тухайн хадгаламж, зээлийн хоршооны болзошгүй алдагдлыг хаах зориулалттай бөгөөд үйл ажиллагааны үр дүнд бий болсон нөөц сангууд, ашиг болон гишүүдийн хувь хөрөнгийг;

5.1.5. “Нэгдмэл сонирхолтой этгээд” гэж хадгаламж, зээлийн хоршооны гишүүн, тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтны эхнэр, нөхөр, эцэг, эх, ах эгч, дүү, хүүхдийг;

5.1.6. “Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт” гэж Хорооноос зохих журмын дагуу тогтоосон, тусгай зөвшөөрөл бүхий хадгаламж, зээлийн хоршоо тогтмол биелүүлж ажиллах санхүүгийн бүлэг харьцаа үзүүлэлтийг;

5.1.7. “Зээлийн эрсдэлийн сан” гэж олгосон зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлт, хугацаа, барьцаа, батлан даалтын найдвартай байдал зэргийг харгалзан зээлийг ангилж, зээлийн багцаас учирч болзошгүй эрсдэлийг Хорооноос тогтоосон журмын дагуу тооцож байгуулсан санг;

5.1.8. “Нөөц сан” гэж ирээдүйд учирч болзошгүй алдагдлыг нөхөх зорилгоор ашгаас хуваарилалт хийх замаар байгуулсан хуримтлуулсан нөөцийг;

5.1.9. “Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар” гэж бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг анхны шаардлагаар гүйцэтгэх нөөцийг;

5.1.10. “Төв хадгаламж, зээлийн хоршоо” гэж тусгай зөвшөөрөл бүхий хадгаламж, зээлийн хоршоодын гишүүнчлэлтэй, тэдгээрт санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх зорилгоор байгуулагдсан Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий дундын санхүүгийн байгууллагыг;

5.1.11. “Тогтворжилтын сан” гэж хадгаламж, зээлийн хоршоог санхүүгийн эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэх, үйл ажиллагааг тогтворжуулах зорилго бүхий санг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА

6 дугаар зүйл. Хадгаламж, зээлийн хоршооны эрхлэх үйл ажиллагаа

6.1. Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааг хянах, зохицуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах эрхийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ хэрэгжүүлнэ.

6.2. Хадгаламж, зээлийн үйл ажиллагааг Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл, хуульд нийцүүлэн баталсан дүрэм, журам, нөхцөл шаардлагын үндсэн дээр эрхэлнэ.

6.3. Хадгаламж, зээлийн хоршоог тодорхой хугацаагаар, эсхүл тодорхой бус хугацаагаар байгуулж болно. Хадгаламж, зээлийн хоршооны дүрэмд тодорхой хугацаа заагаагүй бол тухайн хадгаламж, зээлийн хоршоог тодорхой бус хугацаагаар байгуулсанд тооцно.

6.4. Хадгаламж, зээлийн хоршоо нь Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу мөнгөн хадгаламж, зээлийн үйл ажиллагааг эрхэлнэ.

6.5. Хадгаламж, зээлийн хоршоо нь Хорооноос зөвшөөрсөн, хууль тогтоомжоор хориглоогүй санхүүгийн бусад ажил, үйлчилгээг эрхэлж болно.

6.6. Хадгаламж, зээлийн хоршоо нь энэ хуулийн 6.4, 6.5-д зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

6.7. Хадгаламж, зээлийн хоршоо нь Хорооноос тогтоосон хадгаламж, зээлийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтмол хангаж ажиллана.

6.8. Хадгаламж, зээлийн хоршоо салбар байгуулах тохиолдолд Хорооноос зөвшөөрөл авна. Салбарын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг Хорооноос баталсан журмаар зохицуулна.

6.9.Хадгаламж, зээлийн хоршоо нь өөрийн үйл ажиллагааны улмаас үүссэн үүргийг эхний ээлжинд хоршооны гишүүдийн оруулсан хувь хөрөнгөөс бусад хөрөнгөөр, уг хөрөнгө нь хүрэлцэхгүй тохиолдолд хадгаламж, зээлийн хоршооны гишүүний оруулсан хувь хөрөнгөөр хангана.

6.10.Хадгаламж, зээлийн хоршоо нь өөрийн гишүүний бусдын өмнө хүлээх үүргийг хариуцахгүй.

6.11.Хадгаламж, зээлийн хоршоо нь бусдын өмнө хүлээх төрийн үүргийг хариуцахгүй бөгөөд төр нь хадгаламж, зээлийн хоршооны бусдын өмнө хүлээх үүргийг хариуцахгүй.

6.12.Хороо Монгол Улсын, эсхүл гадаад улсын хадгаламж, зээлийн хоршооны болон бусад санхүүгийн байгууллагын зохицуулалт, хяналт шалгалтын байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, мэдээлэл солилцож болно.

7 дугаар зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны хадгаламжийн үйл ажиллагаа

7.1.Тусгай зөвшөөрөл бүхий хадгаламж, зээлийн хоршоо нь бичгээр байгуулсан гэрээний үндсэн дээр зөвхөн гишүүдийнхээ мөнгөн хөрөнгийг хадгалж болно.

7.2.Хадгаламж хэлбэрээр татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгө нь тухайн хадгаламж, зээлийн хоршооны өөрийн хөрөнгөд хамаарахгүй бөгөөд уг хөрөнгийг зөвхөн зээлийн болон Хорооноос зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил, үйлчилгээний эх үүсвэр болгон ашиглахаас бусад зориулалтаар ашиглахыг хориглоно.

7.3.Гишүүний хадгаламжийг барьцаалж, түүнд зээл олгож болно.

7.4.Хадгаламжийг хамтран эзэмшиж болох бөгөөд хамтран эзэмшигч нь хадгаламж, зээлийн хоршооны гишүүн байх эсэх асуудлыг тухайн хадгаламж, зээлийн хоршооны дүрмээр зохицуулна.

7.5.Нэг гишүүнээс авч болох хадгаламжийн хэмжээнд Хороо хязгаарлалт тогтоож болно.

7.6.Хадгаламж, зээлийн хоршоо гишүүдийнхээ хадгаламжийн баталгааг хангах үүрэгтэй.

8 дугаар зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны зээлийн үйл ажиллагаа

8.1.Хадгаламж, зээлийн хоршоо нь энэ хууль болон хадгаламж, зээлийн хоршооны дүрэм, зээлийн үйл ажиллагааны журамд заасны дагуу зөвхөн гишүүддээ зээл олгож болно.

8.2.Зээлийн хэмжээ, зээлийн зориулалт, төрөл, хугацаа болон зээлийн хүүгийн хэмжээг хадгаламж, зээлийн хоршооны дүрэм, эсхүл тэргүүлэгчдийн зөвлөлөөс тогтоож болно.

8.3.Хадгаламж, зээлийн хоршоо олгосон зээлийнхээ чанарт тогтмол хяналт тавьж, болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор зээлийн эрсдэлийн санг зохих журмын дагуу тогтоосон хэмжээгээр тухай бүр байгуулж, ажиллах үүрэгтэй.

8.4.Хадгаламж, зээлийн хоршоо нь зээлийн эргэн төлөлтөд учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах санг Хорооноос баталсан холбогдох журмын дагуу байгуулж, тогтмол хяналт тавина.

8.5.Нэг гишүүн болон нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн хэмжээг Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээр тогтооно.

8.6.Хадгаламж, зээлийн хоршооны дүрэмд өөрөөр заагаагүй бол гишүүддээ олгох зээл нь барьцаа, батлан даалт зэрэг хуулиар хориглоогүй үүргийн гүйцэтгэлийг хангах аргаар хангагдсан байна.

8.7.Гишүүн нь хадгаламж, зээлийн хоршоонд төлөх өр төлбөр, үүргийн гүйцэтгэлийг биелүүлээгүй бол түүний хадгаламжаас хийх гүйлгээг үүргийн гүйцэтгэлээр хязгаарлана.

8.8.Хадгаламж, зээлийн хоршоо нь зээлийн гэрээг Иргэний хуульд заасны дагуу байгуулах ба уг зээлийн гэрээнд Иргэний хуулийн 452.2-т заасны дагуу нэмэгдүүлсэн хүү тооцохоор зааж болно. Хоршооноос олгох зээлд анзыг хэрэглэхгүй.

8.9.Тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүд, гишүүнчлэл бүхий гүйцэтгэх захирал, ажилтанд зээл олгоход тэдгээрийн хашиж буй албан тушаалаас нь хамаарч аливаа давуу байдал, эсхүл хөнгөлөлт эдлүүлж болохгүй.

8.10.Тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүд, гишүүнчлэл бүхий гүйцэтгэх захирал, ажилтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдэд зээл олгох асуудлыг шийдвэрлэх ажиллагаанд тухайн албан тушаалтан оролцохыг хориглоно.

9 дүгээр зүйл.Хадгаламж, зээлийн үйл ажиллагаанд хориглох зүйл

9.1.Хадгаламж, зээлийн үйл ажиллагаанд дор дурдсан зүйлийг хориглоно:

9.1.1.тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн буюу хүчингүй болгосноос хойш Хорооноос хязгаарлалт тогтоосон үйл ажиллагаа эрхлэх;

9.1.2.гишүүн бус этгээдэд зээл олгох, мөнгөн хадгаламж татах;

9.1.3.банк, санхүүгийн байгууллага, төсөл болон хөтөлбөрөөс бусад этгээдээс зээл, зээлтэй адилтгах нөхцөлөөр аливаа хөрөнгө татан төвлөрүүлэх;

9.1.4.санхүүгийн тайланд тусгагдаагүй хөрөнгийн эх үүсвэрийг хадгаламж, зээлийн үйл ажиллагаанд ашиглах;

9.1.5.зээлийн барьцааны зүйлийг зээл төлүүлэхээс бусад зорилгоор ашиглах, захиран зарцуулах;

9.1.6.ирээдүйн орлогын талаар таамаглал дэвшүүлсэн, эсхүл орлого, хонжвор амласан олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан зар сурталчилгаа хийх, олон нийтийн дунд төлбөрт таавар, бооцоот тоглоом, хонжвор бүхий сугалаа зохион байгуулах, хадгаламжийн болон зээлийн хүүг нийтэд сурталчлах;

9.1.7.өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа мэдээлэл нийтэд тараах;

9.1.8.төв хадгаламж, зээлийн хоршоонд хувь нийлүүлэхээс бусад тохиолдолд хуулийн этгээдэд хувь нийлүүлэх, үнэт цаас худалдах, худалдан авах;

9.1.9.бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэсэнээс бусад тохиолдолд гишүүн болон гишүүн бус этгээдэд хандив өгөх, мөнгөн бус хандив авах.

9.1.10.аливаа улс төрийн нам, эсхүл улс төрийн компанит ажлыг ивээн тэтгэх;

9.2.Тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүнд цалин олгохгүй бөгөөд тэдгээрийн сонгуульт үүрэгтэй холбогдон гарсан зардлыг нөхөн олгож болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООГ ҮҮСГЭН БАЙГУУЛАХ

10 дугаар зүйл.Хадгаламж,зээлийн хоршоо үүсгэн байгуулах

10.1.Монгол Улсын иргэн хадгаламж, зээлийн хоршоог үүсгэн байгуулж болно.

11 дүгээр зүйл.Хадгаламж, зээлийн хоршоо үүсгэн байгуулах гэрээ

11.1.Хадгаламж, зээлийн хоршоо үүсгэн байгуулагчид үүсгэн байгуулах гэрээ байгуулах бөгөөд гэрээнд дараах зүйлийг тусгана:

11.1.1.үүсгэн байгуулах гэрээг байгуулсан газар, хугацаа;

11.1.2.үүсгэн байгуулагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, регистрийн дугаар, эрхэлсэн ажил, албан тушаал;

11.1.3.үүсгэн байгуулах хадгаламж, зээлийн хоршооны оноосон нэр;

11.1.4.хадгаламж, зээлийн хоршоо үүсгэн байгуулагчдын эрх, үүрэг, хариуцлага;

11.1.5.хадгаламж, зээлийн хоршоо үүсгэн байгуулагчдын оруулах хувь хөрөнгийн хэмжээ, хадгаламж, тэдгээрийг захиран зарцуулах;

11.1.6.хадгаламж, зээлийн хоршоог үүсгэн байгуулж чадаагүй нөхцөлд оруулсан хувь хөрөнгө болон хадгаламжаас холбогдох зардлыг хасаж тооцон үлдэгдлийг гишүүдэд буцаан олгох;

11.1.7.хадгаламж, зээлийн хоршоо үүсгэн байгуулагчдын хооронд үүсэх маргааныг шийдвэрлэх.

11.1.8. тусгай зөвшөөрөл авсны дараа үүсгэн байгуулах үеийн зардлыг нөхөн авч болно.

11.2. Үүсгэн байгуулах гэрээнд үүсгэн байгуулагч бүр гарын үсэг зурна.

11.3.Хадгаламж, зээлийн хоршоог үүсгэн байгуулах гэрээг байгуулснаас хойш 60 хоногийн дотор үүсгэн байгуулах хурлыг хуралдуулна.

12 дугаар зүйл.Хадгаламж, зээлийн хоршоо үүсгэн байгуулах үйл ажиллагааны тайлан

12.1.Үүсгэн байгуулагчид хадгаламж, зээлийн хоршоо үүсгэн байгуулах үйл ажиллагааны тайлангийн төслийг боловсруулна.

12.2.Хадгаламж, зээлийн хоршоо үүсгэн байгуулах үйл ажиллагааны тайланд дор дурдсан зүйлийг тусгана:

12.2.1.үүсгэн байгуулах зардал;

12.2.2.үүсгэн байгуулагчдын оруулсан хувь хөрөнгө, хадгаламж болон тухайн хадгаламж, зээлийн хоршооны өөрийн хөрөнгийн талаарх мэдээлэл;

12.2.3.үүсгэн байгуулагчдын үйл ажиллагааны улмаас үүссэн бөгөөд хадгаламж, зээлийн хоршоонд шилжих эрх, үүргийн талаарх мэдээлэл, холбогдох баримт.

13 дугаар зүйл.Хадгаламж, зээлийн хоршоо үүсгэн байгуулах хурал

13.1.Үүсгэн байгуулагчид нь дараах шаардлагыг хангаснаар үүсгэн байгуулах хурал хуралдуулах шийдвэр гаргаж, хурлыг зарлан хуралдуулж болно:

13.1.1.хадгаламж, зээлийн хоршоо үүсгэн байгуулагчдын тоо 20 хүрсэн;

13.1.2.хадгаламж, зээлийн хоршоо үүсгэн байгуулах гэрээг байгуулсан;

13.1.3.хуульд нийцүүлэн хадгаламж, зээлийн хоршооны дүрмийн төслийг боловсруулсан;

13.1.4.хадгаламж, зээлийн хоршоо үүсгэн байгуулагч хоршоо байгуулахад оруулах хувь хөрөнгө, оруулахаар тохирсон хадгаламжийг бэлнээр төвлөрүүлсэн;

13.1.5.үүсгэн байгуулагчдын оруулах хувь хөрөнгийн дүн нь хоршооны дүрмээр тогтоосон гишүүний оруулах хувь хөрөнгийн дүнтэй ижил байна.

13.2.Хадгаламж, зээлийн хоршоо үүсгэн байгуулах хуралд бүх гишүүд оролцоноор тухайн үүсгэн байгуулах хурал хүчин төгөлдөр болно.

13.3.Хадгаламж, зээлийн хоршоо үүсгэн байгуулах хурлын дарга, нарийн бичгийн даргыг хуралд оролцогчдын олонхийн саналаар сонгоно.

13.4.Хадгаламж, зээлийн хоршоо үүсгэн байгуулах хурлын дарга нь шударга, нээлттэй байх зарчмыг баримтлан хурлын дэгийг хэлэлцүүлэн тогтоож, хурлыг удирдан явуулна.

13.5.Хадгаламж, зээлийн хоршоо үүсгэн байгуулах хурлаар дараах асуудлыг хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэрлэнэ:

13.5.1.хадгаламж, зээлийн хоршоог үүсгэн байгуулах эсэх;

13.5.2.хадгаламж, зээлийн хоршоо үүсгэн байгуулах үйл ажиллагааны тайлан;

13.5.3.хадгаламж, зээлийн хоршооны дүрмийн төсөл;

13.5.4.хадгаламж, зээлийн хоршооны тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох.

13.6.Хадгаламж, зээлийн хоршоо үүсгэн байгуулах хурлын явцад тэмдэглэл хөтлөх бөгөөд тэмдэглэлд хурал удирдсан дарга, нарийн бичгийн дарга болон хуралд оролцсон бусад үүсгэн байгуулагч гарын үсэг зурж баталгаажуулна.

13.7.Хадгаламж, зээлийн хоршоо үүсгэн байгуулах хурлын тэмдэглэлд дор дурдсан зүйлийг тусгасан байна:

13.7.1.хуралдсан он, сар, өдөр, газар;

13.7.2.хуралд оролцсон үүсгэн байгуулагчдын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр;

13.7.3.хурлын ирц;

13.7.4.хурлаар хэлэлцсэн асуудал, гарсан санал, дэмжсэн саналын хувь, шийдвэр.

13.8.Хадгаламж, зээлийн хоршоо үүсгэн байгуулах хурлын шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх бөгөөд хурал удирдсан дарга гарын үсэг зурна.

13.9.Хадгаламж, зээлийн хоршоо үүсгэн байгуулах хурал хуралдсанаас хойш ажлын таван өдөрт багтаан үүсгэн байгуулагчид үүсгэн байгуулах үйл ажиллагааны тайлан болон төвлөрсөн хөрөнгийг тэргүүлэгчдийн зөвлөлд хүлээлгэн өгнө.

13.10.Тэргүүлэгчдийн зөвлөл нь хадгаламж, зээлийн хоршоог бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлж, энэ хуулийн 15 дугаар зүйлд зааснаар Хороонд хандана.

14 дүгээр зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны дүрэм

14.1.Хадгаламж, зээлийн хоршооны дүрэм нь түүний үйл ажиллагааг зохицуулах үндсэн баримт бичиг бөгөөд түүнд дор дурдсан зүйлийг заавал тусгана:

14.1.1.хадгаламж, зээлийн хоршооны оноосон нэр, оршин байгаа газрын хаяг;

14.1.2.хадгаламж, зээлийн хоршоог тодорхой хугацаагаар байгуулж байгаа бол уг хугацаа;

14.1.3.эрхлэх үйл ажиллагааны төрөл;

14.1.4.гишүүнчлэлийн нөхцөл, шаардлага, идэвхтэй болон идэвхгүй гишүүний эрх, үүрэг, хариуцлага;

14.1.5.хадгаламж, зээлийн хоршоонд гишүүнээр элсэх, гишүүний эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, гарах болон гишүүнээс хасах;

14.1.6.хадгаламж, зээлийн хоршооны гишүүний оруулах хувь хөрөнгийн хэмжээ;

14.1.7.бүх гишүүдийн хурлын эрх хэмжээ, хурлыг хуралдуулах, санал хураах;

14.1.8.тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх, эгүүлэн татах журам;

14.1.9.тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хорооны үйл ажиллагаа;

14.1.10.тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, гүйцэтгэх захирлын бүрэн эрх, хугацаа, хариуцлага;

14.1.11.жил, улирлын тайлан гаргах, бүх гишүүдийн хурал, хяналтын зөвлөлд тайлагнах;

14.1.12.тухайн жилийн орлогыг хуваарилах, алдагдлыг нөхөх хэлбэр;

14.1.13.нөөцийн санг бүрдүүлэх, түүнийг зарцуулах асуудал;

14.1.14.хадгаламж хамгаалалтын болон тогтворжилтын сангийн асуудал;

14.1.15.нэг гишүүн болон нэгдмэл сонирхолтой этгээдэд олгох зээлийн дээд хэмжээ, хугацаа хэтэрсэн зээлтэй гишүүнд хүлээлгэх хариуцлага;

14.1.16.данс нээх, хаах, дансны мэдээлэлтэй танилцах;

14.1.17.сонирхлын зөрчил бүхий үйлдлийн талаарх зохицуулалт;

14.1.18.хадгаламж, зээлийн хоршоог өөрчлөн байгуулах, татан буулгах;

14.1.19.дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;

14.1.20.холбогдох шийдвэр, үйл ажиллагааны талаарх мэдээ, тайланг гишүүд, холбогдох бусад этгээдэд хүргэх, мэдээлэх;

14.1.21.нууцад хамаарах мэдээлэл.

14.2.Хадгаламж, зээлийн хоршооны дүрэмд энэ хуулийн 14.1-д зааснаас бусад зүйлийг хууль тогтоомжид нийцүүлэн тусгаж болно.

14.3.Хадгаламж, зээлийн хоршооны загвар дүрмийг Хороо батална.

14.4.Хадгаламж, зээлийн хоршооны дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг энэ тухай шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор Хороонд хүргүүлнэ.

15 дугаар зүйл.Хадгаламж, зээлийн хоршоог хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх

15.1.Хадгаламж, зээлийн хоршоо нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль тогтоомжийн дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлд хоршоо хэлбэрээр бүртгүүлсний дараа Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар Санхүүгийн зохицуулах хороонд хандана.

15.2.Улсын бүртгэлд бүртгүүлсэн болон тусгай зөвшөөрөл авахаар хандсан, олгосон эсэх талаарх мэдээллийг Хороо болон улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хооронд сар тутам солилцоно.

16 дугаар зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны нэр

16.1.Хадгаламж, зээлийн хоршоо нь оноосон нэртэй байх бөгөөд түүнийг хэрэглэх тохиолдол бүрд уг нэрийн ард “Хадгаламж, зээлийн хоршоо” гэсэн дэлгэрэнгүй тэмдэглэгээ, эсхүл “ХЗХ” гэсэн товчилсон тэмдэглэгээ заасан байна.

16.2.Хорооноос тусгай зөвшөөрөл олгосны дараа хоршоо нь улсын бүртгэлийн байгууллагад хандаж холбогдох өөрчлөлтийг хийлгэсний дараа ХЗХ гэсэн тэмдэглэгээ хэрэглэнэ.

16.3.Хадгаламж, зээлийн хоршооны оноосон нэрд хэн нэг үүсгэн байгуулагч гишүүний нэр, эсхүл өөр хуулийн этгээдийн төрөл, зохион байгуулалтыг илэрхийлсэн нэр, тэмдэглэгээ хэрэглэхийг хориглоно.

16.4.Хадгаламж, зээлийн хоршооны өөрийн оноосон нэрийг Хорооны зөвшөөрлөөр өөрчилж болно.

16.5.Тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон хадгаламж, зээлийн хоршооны нэрийг дахин ашиглахгүй.

17 дугаар зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны оршин байгаа газар

17.1.Хадгаламж, зээлийн хоршоо нь өөрийн оршин байгаа газрын хууль ёсны хаяг өөрчлөгдсөн тохиолдолд ажлын долоон өдрийн дотор Хороо болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллагад бичгээр мэдэгдэж, холбогдох өөрчлөлтийг бүртгүүлнэ.

18 дугаар зүйл.Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг

18.1.Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16.1, 21 дүгээр зүйлд заасан баримт бичгээс гадна дараах баримт бичгийг бүрдүүлнэ:

18.1.1.Хорооноос баталсан маягтын дагуу гаргасан өргөдөл;

18.1.2.хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ;

18.1.3.үүсгэн байгуулах хурлаас гаргасан үүсгэн байгуулах тухай шийдвэр;

18.1.4.үүсгэн байгуулагчдын хооронд байгуулсан үүсгэн байгуулах тухай гэрээ;

18.1.5.үүсгэн байгуулагчдын талаарх мэдээлэл;

18.1.6.хадгаламж, зээлийн хоршооны дүрэм;

18.1.7.хадгаламж, зээлийн хоршооны өөрийн хөрөнгийн хэмжээ;

18.1.8.үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө;

18.1.9.хадгаламжийн үйл ажиллагааны журам;

18.1.10.зээлийн хороо болон зээлийн үйл ажиллагааны журам;

18.1.11.эхлэлтийн баланс;

18.1.12.тэргүүлэгчид, хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал, нягтлан бодогчийн мэргэжил, мэргэшил, ур чадварын талаарх мэдээлэл;

18.1.13.Хорооноос баталсан хадгаламж, зээлийн хоршоонд тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулсан журамд заасан бусад баримт бичиг.

18.2.Энэ хуулийн 18.1-д заасны дагуу бүрдүүлж өгсөн баримт бичгийг дутуу буюу тодорхой бус гэж үзвэл Хороо нэмэлт баримт шаардах эрхтэй бөгөөд үүсгэн байгуулагч

гишүүнтэй холбоотой асуудлаар хуулийн байгууллагаас тодорхойлолт, лавлагаа гаргуулан авч болно.

19 дүгээр зүйл.Хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох

19.1.Хороо нь энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох бусад баримт бичгийг хянан үзэж, бүрэн гүйцэд баримт бичиг хүлээн авснаас хойш ажлын 45 өдрийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэх тухай асуудлыг шийдвэрлэнэ.

19.2.Энэ хуулийн 6.4-т заасан үйл ажиллагаа эрхлэхэд тавигдах нөхцөл, шаардлага, тэдгээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгох, хэрэгжилтэд хяналт тавих, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон нөхцөл, шаардлагыг Хороо тогтооно.

19.3.Хороо нь дараах нөхцөл, шаардлагыг хангасан хадгаламж, зээлийн хоршоонд тусгай зөвшөөрөл олгоно:

19.3.1.өргөдөл, түүний бүрдэл баримт бичиг нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан;

19.3.2.тухайн хадгаламж, зээлийн хоршооны тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хороо, тэдгээрийн гишүүд, гүйцэтгэх захирал, ажилтан нь хуульд заасан шаардлагыг хангасан;

19.3.3.үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө нь бодитой, үйл ажиллагаанаас учирч болзошгүй эрсдэлээс хамгаалах арга хэмжээг тусгасан;

19.3.4.холбогдох хууль, журмаар тогтоосон нөхцөл, шаардлагыг хангасан.

19.4.Энэ хуулийн 19.3-т заасан нөхцөл, шаардлагыг хангаагүй тохиолдолд Хороо тусгай зөвшөөрөл олгохоос татгалзаж, энэ тухай үндэслэл бүхий хариу өгнө.

19.5.Тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгох ба уг зөвшөөрөл нь олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилнэ.

19.6.Хороо нь хүсэлт гаргасан хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаа явуулах засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх санхүүгийн үйлчилгээний хүртээмж, зах зээлийн орчинд үндэслэн тусгай зөвшөөрөл олгохоос татгалзаж болно.

19.7.Өргөдөл гаргагч нь Хорооны тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шийдвэр хүлээн авснаас хойш ажлын 15 хоногийн дотор гомдлоо Хорооны дэргэдэх хяналтын зөвлөлд гаргана.

19.8.Хорооноос тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэрт энэ хуулийн 19.7-д заасан хугацаанд гомдол гаргаагүй, гомдол гаргах хугацаа өнгөрсөн, эсхүл уг гомдлыг шийдвэр хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор дахин тусгай зөвшөөрөл хүсэх тухай өргөдөл гаргаагүй бол Хороо нь тухайн хадгаламж, зээлийн хоршоог татан буулгах, эсхүл хуулийн этгээдийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах тухай мэдэгдлийг тухайн хадгаламж, зээлийн хоршоонд, мэдээллийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

19.9.Хадгаламж, зээлийн хоршоог хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш энэ хуулийн 19.1-д заасан хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тусгай зөвшөөрөл хүсэх тухай өргөдөл гаргаагүй, эсхүл уг хугацаанд тухайн хадгаламж, зээлийн хоршооны эрх бүхий этгээд хуулийн этгээдийн улсын бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлт гаргаагүй нь тухайн хадгаламж, зээлийн хоршоог шүүх татан буулгах үндэслэл болно.

19.10.Хорооноос тусгай зөвшөөрөл олгосноос хойш нэг жилийн хугацаанд тусгай зөвшөөрлөөр олгогдсон үйл ажиллагааг эрхлээгүй, эсхүл эрхэлсэн боловч үйл ажиллагаа нь нэг жилийн хугацаанд тасалдсан хадгаламж, зээлийн хоршооны тусгай зөвшөөрлийг Хороо хүчингүй болгож болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ГИШҮҮНЧЛЭЛ

20 дугаар зүйл. Хадгаламж, зээлийн хоршооны гишүүнчлэл

20.1. Хадгаламж, зээлийн хоршоо нь 20-оос доошгүй гишүүнтэй байна.

20.2. Энэ хууль болон түүнд нийцүүлэн баталсан тухайн хадгаламж, зээлийн хоршооны дүрмээр тогтоосон шаардлагыг хангасан эрх зүйн бүрэн чадамж бүхий Монгол Улсын иргэн, хуулийн этгээд хоршооны гишүүнээр элсэж болно.

20.3. Хадгаламж, зээлийн хоршооны гишүүн дор дурдсан нөхцөлийн аль нэгийг нь хангасан байна:

20.3.1. Эрхлэх үйл ажиллагаа, ажил, мэргэжил нэгтэй;

20.3.2. нэг нийгэмлэг, холбоонд гишүүнчлэлтэй ;

20.3.3. нэг аймаг, хот, дүүрэгт амьдардаг.

20.4. Хадгаламж, зээлийн хоршооны гишүүний гэр бүл, төрөл садангийн хүмүүс тухайн хадгаламж, зээлийн хоршоонд гишүүнээр элсэж болно. Энэ тохиолдолд нэгдмэл сонирхолтой этгээд болохоо хадгаламж, зээлийн хоршоонд урьдчилан мэдэгдэнэ.

20.5. Нийт гишүүний 10-аас дээшгүй хувь нь хуулийн этгээд байж болно.

20.6. Санхүүгийн салбарт тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд хадгаламж, зээлийн хоршооны гишүүн байхыг хориглоно.

20.7. Энэ хуулийн 20.1-20.4-т заасан гишүүнээр элсэхэд тавигдах шаардлагад нийцүүлэн бусад шаардлагыг хадгаламж, зээлийн хоршоо өөрийн дүрмээр тогтоож болно.

20.8. Хадгаламж, зээлийн хоршооны гишүүдийн тоо энэ хуулийн 20.1-д заасан хязгаарт хүрэхгүй болсон тохиолдолд тэргүүлэгчдийн зөвлөл бүх гишүүдийн хурлыг ажлын 30 өдрийн дотор хуралдуулж, татан буулгах эсэх асуудлыг хэлэлцүүлнэ.

20.9. Хадгаламж, зээлийн хоршооны дүрэмд өөрөөр заагаагүй бол гишүүний эрх нь хадгаламж, зээлийн хоршоонд оруулах хувь хөрөнгийг бүрэн оруулснаар үүснэ.

20.10. Хадгаламж, зээлийн хоршооны дүрмээр зөвшөөрөөгүй бол тухайн хоршооны гишүүн нь өөр хадгаламж, зээлийн хоршооны гишүүн байхыг хориглоно.

21 дүгээр зүйл. Гишүүний бүртгэл

21.1. Тэргүүлэгчдийн зөвлөл нь гишүүдийн бүртгэлийг хөтөлж, хадгалах ба түүний үнэн зөвийг хариуцаж, гарсан өөрчлөлтийг хуульд заасан хугацаанд Хороонд мэдэгдэнэ.

21.2. Тэргүүлэгчдийн зөвлөл, гүйцэтгэх захирал болон албан тушаалтан нь тухайн этгээдэд хамаарах гишүүний бүртгэлд туссан мэдээллийг саадгүй гаргаж өгөх, холбогдох баримт бичигтэй танилцах боломжоор хангах үүрэгтэй.

22 дугаар зүйл. Гишүүнээр элсэх

22.1. Гишүүнээр элсэх журмыг хадгаламж, зээлийн хоршооны дүрмээр тогтооно.

22.2. Гишүүнээр элсэхийг хүссэн этгээд өргөдлөө тэргүүлэгчдийн зөвлөлд гаргана.

22.3. Дүрэмд өөрөөр заагаагүй бол гишүүнээр элсүүлэх эсэхийг тэргүүлэгчдийн хурлаар 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

22.4. Хадгаламж, зээлийн хоршоо нь гишүүн элсүүлэхдээ гишүүний заавал оруулах хувь хөрөнгө, гишүүний хураамжаас бусад төлбөр шаардах эрхгүй.

23 дугаар зүйл. Гишүүнчлэлээс гарах

23.1. Гишүүн нь өөрийн хүсэлтээр хадгаламж, зээлийн хоршооны гишүүнчлэлээс гарч болно. Тэргүүлэгчдийн зөвлөл нь гишүүнээс гарах мэдэгдлийг бичгээр хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор энэ хуулийн 25.2-т зааснаас бусад тооцоог хийнэ.

23.2. Энэ хуулийн 20.2-т заасан шаардлагыг хангахгүй болсон гишүүн энэ тухайн хадгаламж, зээлийн хоршоонд сайн дураар мэдэгдэнэ. Энэ үүргийг биелүүлээгүй нь тухайн гишүүнийг гишүүнчлэлээс хасах үндэслэл болох бөгөөд түүний гишүүний бүрэн эрхийг энэ хуулийн 20.2-т заасан шаардлагыг хангахгүй болсон өдрөөр дуусгавар болсонд тооцно.

24 дүгээр зүйл. Гишүүнээс хасах, гишүүний эрхийг түдгэлзүүлэх

24.1.Гишүүн нь энэ хууль, хадгаламж, зээлийн хоршооны дүрэм болон бусад журам, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, санаатай зөрчсөн, заавал оруулах хувь хөрөнгийг бүрэн оруулаагүй, гишүүний эрх, үүрэг, хувь хөрөнгөө тухайн хадгаламж, зээлийн хоршооны бусад гишүүнд шилжүүлэх замаар гишүүнчлэлээс гарсан, эсхүл идэвхгүй гишүүнд тооцогдсоноос хойш тогтоосон хугацаанд гишүүнээр үлдэх тухай хүсэлтээ хадгаламж, зээлийн хоршоонд гаргаагүй бол тэргүүлэгчдийн зөвлөлийн шийдвэрээр гишүүнээс түдгэлзүүлэх, гишүүнээс хасч болно.

24.2.Хадгаламж, зээлийн хоршоо энэ хуулийн 23.1-д заасан гишүүнд түүний гишүүнчлэлийн асуудлыг хэлэлцэх тэргүүлэгчдийн зөвлөлийн хуралд оролцох боломжийг олгоно.

24.3.Гишүүнээс хассан тухай шийдвэрийг эс зөвшөөрвөл түдгэлзүүлсэн буюу хасагдсан тухайн гишүүн энэ тухай шийдвэр гарснаас хойш бүх гишүүдийн хуралд гомдол гаргаж болно.

24.4.Түдгэлзүүлсэн гишүүн бүх гишүүдийн хурлаар түүний гишүүнчлэлийн асуудлыг шийдвэрлэх хүртэлх хугацаанд энэ хууль болон хадгаламж, зээлийн хоршооны дүрэмд заасан гишүүний эрхийг эдлэхгүй.

24.5.Дор дурдсан тохиолдолд тэргүүлэгчдийн зөвлөлийн шийдвэрээр гишүүнээс хасаж болно:

24.5.1.гишүүн нь энэ хууль, хадгаламж, зээлийн хоршооны дүрэм болон бусад журам, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, санаатай зөрчсөн;

24.5.2.заавал оруулах хувь хөрөнгийг бүрэн оруулаагүй;

24.5.3.гишүүний эрх, үүрэг, хувь хөрөнгөө тухайн хадгаламж, зээлийн хоршооны бусад гишүүнд шилжүүлэх замаар гишүүнчлэлээс гарсан;

24.5.4.идэвхгүй гишүүнд тооцогдсоноос хойш тогтоосон хугацаанд гишүүнээр үлдэх тухай хүсэлтээ хадгаламж, зээлийн хоршоонд гаргаагүй.

24.6.Энэ хуулийн 24.5-д заасан асуудлыг хэлэлцэхэд тухайн гишүүнийг тэргүүлэгчдийн зөвлөлийн хуралд оролцох боломжийг олгоно.

24.7.Гишүүнээс хассан тухай шийдвэрийг эс зөвшөөрвөл тухайн гишүүн энэ тухай шийдвэр гарснаас хойш бүх гишүүдийн хуралд гомдол гаргана.

24.8.Тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлаас хасах шийдвэр гаргасан гишүүний гишүүнчлэлийн асуудлыг бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэх хүртэлх хугацаанд тухайн гишүүн энэ хууль болон хадгаламж, зээлийн хоршооны дүрэмд заасан гишүүний эрхийг эдлэхгүй.

25 дугаар зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны гишүүний эрх дуусгавар болох

25.1.Дор дурдсан тохиолдолд хоршооны гишүүний эрх нь дуусгавар болно:

25.1.1.хоршооны гишүүний гишүүнчлэлээс гарах хүсэлтийг тэргүүлэгчдийн зөвлөл зөвшөөрсний дагуу гишүүнчлэлийн бүртгэлээс хассанаар;

25.1.2.хоршооны гишүүн нь эрхээ бусдад шилжүүлсний дагуу гишүүнчлэлийн бүртгэлд өөрчлөлт хийснээр;

25.1.3.тухайн хадгаламж, зээлийн хоршооны дүрмээр давхар гишүүнчлэлийг зөвшөөрөөгүй тохиолдолд, эсхүл өөр хадгаламж, зээлийн хоршоонд давхар гишүүнчлэлтэй болсон.

25.2.Дор дурдсан тохиолдолд хоршооны гишүүний эрх дуусгавар болсонд тооцогдоно:

25.2.1.гишүүн эрх зүйн бүрэн чадамжаа алдсан;

25.2.2.гишүүн нас барсан буюу нас барсан гэж тооцогдсон;

25.2.3.гишүүн хуулийн этгээд татан буугдсан, төлбөрийн чадваргүй болсон.

25.3.Хадгаламж, зээлийн хоршоо татан буугдсанаар гишүүнчлэл дуусгавар болно.

26 дугаар зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны гишүүний эрх нь дуусгавар болсон этгээдтэй тооцоо хийх

26.1.Гишүүний эрх нь дуусгавар болсон, дуусгавар болсонд тооцогдсон гишүүнтэй хийх оруулсан хувь хөрөнгөтэй холбоотой төлбөр тооцооноос бусад өр төлбөрийн тооцоог тухайн гишүүний эрх нь дуусгавар болсон буюу дуусгавар болсонд тооцогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор хийж гүйцэтгэнэ.

26.2.Эрх нь дуусгавар болсон гишүүний оруулсан хувь хөрөнгө нь хадгаламж, зээлийн хоршооны өөрийн хөрөнгөд тооцогдох бөгөөд хоршооны нөөцийн санд шилжүүлнэ.

26.3.Гишүүний эрх нь дуусгавар болсон буюу дуусгавар болсонд тооцогдсон этгээдтэй хийх тооцоотой холбогдсон гомдлыг зохих журмын дагуу шүүхэд гаргаж болно.

27 дугаар зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны гишүүний эрх, үүрэг

27.1.Хадгаламж, зээлийн хоршооны гишүүн дор дурдсан эрх эдэлнэ.

27.1.1.бүх гишүүдийн хуралд саналын нэг эрхтэй оролцох;

27.1.2.бүх гишүүдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах саналыг гаргах;

27.1.3.тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүнийг сонгох, сонгогдох;

27.1.4.гишүүнчлэл бүхий хадгаламж, зээлийн хоршоондоо мөнгөн хөрөнгөө хадгалуулах, зээл авах болон бусад үйлчилгээнд хамрагдах;

27.1.5.бүх гишүүдийн хурал, тэргүүлэгчдийн зөвлөлийн хууль бус үйл ажиллагааны талаар Хороонд гомдол гаргах;

27.1.6.гишүүнчлэлээс гарах;

27.1.7.энэ хууль, хадгаламж, зээлийн хоршооны дүрмээр тогтоосон хязгаарын хүрээнд хувь хөрөнгө оруулах, өөрийн оруулсан хувь хөрөнгөтэй хувь тэнцүүлэн хадгаламж, зээлийн хоршооны жилийн орлогоос тогтоосон журмын дагуу хувь хөрөнгө авах;

27.1.8.хадгаламж, зээлийн хоршоо татан буугдсан тохиолдолд үлдсэн эд хөрөнгөөс оруулсан хувь хөрөнгөтэй хувь тэнцүүлэн хувь хөрөнгө авах;

27.1.9.хадгаламж, зээлийн хоршооны дүрмээр тогтоосон бусад эрх.

27.2.Хадгаламж, зээлийн хоршооны гишүүн дор дурдсан үүрэг хүлээнэ:

27.2.1.хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд оролцож, үйл ажиллагааны талаар мэдээлэл авах, түүний санхүү, эдийн засгийн болон хөрөнгийн байдал, жил, улирлын санхүүгийн тайлан, мэдээ, тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн шийдвэр, тэдгээрийн үйл ажиллагааны тайлан, бүх гишүүдийн хурлын тэмдэглэл, гишүүдийн бүртгэлтэй холбоотой нууцад хамаарахаас бусад мэдээлэлтэй тогтмол танилцах;

27.2.2.хувь хөрөнгийг тогтоосон хугацааны дотор оруулах;

27.2.3.хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд биечлэн оролцох, бүх гишүүдийн хурал, тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, гүйцэтгэх захирлын гаргасан шийдвэрийг биелүүлэх;

27.2.4.хадгаламж, зээлийн болон бусад гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;

27.2.5.гишүүний бүртгэлд тусгагдсан мэдээллийн өөрчлөлтийг тухай бүр шуурхай мэдэгдэх;

27.2.6.тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн шийдвэр, тэдгээрийн үйл ажиллагааны тайлан, бүх гишүүдийн хурлын тэмдэглэл, гишүүдийн бүртгэлтэй танилцах.

28 дугаар зүйл.Гишүүний хүлээх хариуцлага

28.1.Хадгаламж, зээлийн хоршооны гишүүн нь энэ хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журам, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөний улмаас хадгаламж, зээлийн хоршоонд учруулсан хохирлыг иргэн хувийн өмчийн хөрөнгөөр, хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр бүрэн барагдуулна.

28.2.Хадгаламж, зээлийн хоршооны бусдын өмнө хүлээх хариуцлагыг гишүүн нь зөвхөн өөрийн оруулсан хувь хөрөнгийн хэмжээгээр хариуцах ба хувийн өмчийн хөрөнгөөрөө хариуцахгүй.

28.3.Хадгаламж, зээлийн хоршоонд учруулсан хохирлыг нөхөн төлөхөөс зайлсхийх зорилгоор, эсхүл хууль бус үйлдлээ халхавчлах үүднээс олсон ашиг, орлого, эд хөрөнгөө бусдын өмчлөлд буюу хамтран өмчлөх дундын эд хөрөнгөд шилжүүлсэн нь нотлогдвол тэр хэмжээгээр тухайн эд хөрөнгөөс төлбөр гаргуулна.

28.4.Энэ хуулийн 28.1-д заасан зөрчлийн улмаас гишүүнээс хассан буюу гишүүний эрхийг түдгэлзүүлсэн нь тухайн гишүүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

ТАВДУГААР БҮЛЭГ **ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,** **УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТ**

29 дүгээр зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны зохион байгуулалт

29.1.Хадгаламж, зээлийн хоршоо нь тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хороо, гүйцэтгэх захирал, ажилтантай байна.

30 дугаар зүйл.Бүх гишүүдийн хурал

30.1.Хадгаламж, зээлийн хоршооны эрх барих дээд байгууллага нь бүх гишүүдийн хурал байна.

30.2.Хадгаламж, зээлийн хоршооны бүх гишүүдийн хурал дор дурдсан бүрэн эрхтэй байна:

- 30.2.1.хадгаламж, зээлийн хоршооны дүрмийг батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;
- 30.2.2.хадгаламж, зээлийн хоршооны бүтэц, зохион байгуулалт, санхүүгийн жилийн үйл ажиллагааны төсвийг баталгаажуулах;
- 30.2.3.хадгаламж, зээлийн хоршоо үүсгэн байгуулах, үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, батлах;
- 30.2.4.тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх, огцруулах;
- 30.2.5.хадгаламжийн болон зээлийн үйл ажиллагааны бодлогыг батлах;
- 30.2.6.тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хороо, бусад үйл ажиллагааны дотоод журмыг батлах;
- 30.2.7.тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагааны талаар гишүүдээс гаргасан гомдол, саналыг авч хэлэлцэх;
- 30.2.8.гишүүний оруулах хувь хөрөнгийн хэмжээг тогтоох, өөрчлөх;
- 30.2.9.тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, дотоод аудитын үйл ажиллагааны зардлын хязгаар, урамшууллын хэмжээг тусгайлан санал хурааж тогтоох;
- 30.2.10.хадгаламж, зээлийн хоршоог хөгжүүлэх бодлого, бизнес төлөвлөгөөг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;
- 30.2.11.жилийн санхүүгийн тайланг хэлэлцэж, тухайн жилийн хоршооны орлого хуваарилах, алдагдал нөхөх талаар шийдвэр гаргах;
- 30.2.12.нөөц хөрөнгийн хэмжээг Хорооноос тогтоосон хэмжээнээс багагүй байхаар тогтоох, алдагдлыг нөөц хөрөнгөөс нөхөх талаар шийдвэр гаргах;
- 30.2.13.тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэх;
- 30.2.14.хадгаламж, зээлийн хоршоодын холбоонд нэгдэх асуудлыг шийдвэрлэх;
- 30.2.15.өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах;
- 30.2.16.хууль, дүрэмд заасан бусад асуудал.

31 дүгээр зүйл.Бүх гишүүдийн хурлыг хуралдуулах

31.1.Бүх гишүүдийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна.

31.2.Бүх гишүүдийн ээлжит хурал хуралдуулах тухай шийдвэрийг тэргүүлэгчдийн зөвлөл гаргана.

31.3.Бүх гишүүдийн ээлжит бус хурлыг тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн шийдвэр, эсхүл нийт гишүүний гуравны нэгээс доошгүй хувийн бичгээр гаргасан саналыг үндэслэн тэргүүлэгчдийн зөвлөл зарлан хуралдуулна.

31.4.Энэ хуулийн 31.3-т заасан бүх гишүүдийн ээлжит бус хурлыг хуралдуулах саналд хурал хуралдуулах үндэслэл, хэлэлцэх асуудлын төслийг хавсаргасан байна.

31.5.Дараах тохиолдолд бүх гишүүдийн хурлыг заавал зарлан хуралдуулна:

31.5.1.хадгаламж, зээлийн хоршоог татан буулгах;

31.5.2.хадгаламж, зээлийн хоршооны санхүү, төлбөрийн чадвар муудсан, өөрийн хөрөнгөгүй болсон;

31.5.3.энэ хуулийн 30.3-т заасан эрх бүхий этгээд бүх гишүүдийн хурлыг хуралдуулах санал гаргасан;

31.5.4.бүх гишүүдийн хурал зарлан хуралдуулах талаар Хорооны, эсхүл шүүхийн шийдвэр гарсан.

31.6.Олон тооны эсхүл орон зайн хувьд тархсан гишүүдтэй хадгаламж, зээлийн хоршоо нь Хорооноос зөвшөөрсөн тохиолдолд дараах хэлбэрээр бүх гишүүдийн хурлыг хуралдуулж болно:

31.6.1.Төлөөллийн зарчмаар зохион байгуулж, нэгж бүрээс томилогдсон гишүүн төлөөлөн бүх гишүүдийн хуралд оролцож, санал өгөх эрхтэй бөгөөд хурлын явц, гарсан шийдвэрийн талаар бусад гишүүдэд эргэн мэдээлнэ.

31.6.2.Нэгж бүрт хурлыг зохион байгуулж, нэгж бүр дээр хураасан саналын дүнг нэгтгэж шийдвэр гаргана. Техникийн шаардлагыг хангаж, хурлыг цахим хэлбэрээр нэг дор явуулахыг зөвшөөрнө.

32 дугаар зүйл.Бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах

32.1.Бүх гишүүдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш дараа оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор зарлан хуралдуулна.

32.2.Бүх гишүүдийн ээлжит хурлыг хуралдуулах зар болон хэлэлцэх асуудлын жагсаалтыг хурал хуралдахаас 30-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд хүргэнэ.

32.3.Бүх гишүүдийн хурлын зарыг нэгэн зэрэг хүргэх боломжийг хангаж, мэдээллийн дараах арга, хэрэгслийг ашиглана:

32.3.1.олон нийтийн мэдээллийн хэрэгсэл;

32.3.2.захидал болон хадгаламж, зээлийн хоршооны дүрмээр тогтоосон бусад арга хэрэгсэл.

32.4.Энэ хуулийн 31.3-т заасны дагуу тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, нийт гишүүний гуравны нэгээс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний гишүүдийн бичгээр гаргасан бүх гишүүдийн ээлжит бус хурлыг хуралдуулах санал, эсхүл бүх гишүүдийн ээлжит бус хурлыг хуралдуулах тухай Хороо, шүүхийн шийдвэрийг хүлээн авсан тэргүүлэгчдийн зөвлөл бүх гишүүдийн хурлыг ажлын 30 өдрийн дотор зарлан хуралдуулна.

32.5.Шаардлагатай гэж үзвэл тэргүүлэгчдийн зөвлөл бүх гишүүдийн ээлжит бус хурлыг хэдийд ч зарлан хуралдуулж болох ба хурлын зар болон хэлэлцэх асуудлын жагсаалтыг ажлын 10 өдрийн өмнө гишүүдэд хүргэнэ.

32.6.Хяналтын зөвлөл нь бүх гишүүдийн ээлжит болон ээлжит бус хурлаар хадгаламж, зээлийн хоршооны дотоод ил тод байдал энэ хууль болон дүрмээр тогтоосон хэм хэмжээний хэрэгжилт, хадгаламж, зээлийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, Хорооноос тогтоосон үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хэрхэн хангаж байгаа талаарх дүгнэлтийг заавал хэлэлцүүлнэ.

33 дугаар зүйл.Бүх гишүүдийн хурлын ирц, хурлаас шийдвэр гаргах

33.1.Хадгаламж, зээлийн хоршоо 100 болон түүнээс доош гишүүдтэй бол бүх гишүүдийн хурал нь нийт гишүүний тавиас доошгүй хувь, 101-ээс дээш бол нийт гишүүдийн хориос доошгүй хувь нь оролцсоноор хүчин төгөлдөр болно.

33.2.Энэ хуулийн 33.1-д заасан ирц хүрээгүй бүх гишүүдийн хурлыг дахин зарлан хуралдуулах ба хурал хуралдахаас ажлын таваас доошгүй өдрийн өмнө хурлын зар болон хэлэлцэх асуудлын жагсаалтыг гишүүдэд хүргэнэ. Бүх гишүүдийн хурлын ирцийг бүрдүүлэн тухайн жилийн 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор хуралдуулж чадаагүй тохиолдолд Хорооноос тус хоршооны тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх хүртэл арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

33.3.Бүх гишүүдийн хурлын шийдвэрийг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар гаргана. Бүх гишүүдийн хурлын шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх ба шийдвэрт тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

33.4.Бүх гишүүдийн хуралд гишүүн бүр саналын нэг эрхтэй оролцоно.

33.5.Тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн гишүүдийг нууц санал хураалтын үндсэн дээр сонгох ба бусад асуудлыг дүрэмд заасан санал хураах журмын дагуу шийдвэрлэнэ.

33.6.Гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгааны улмаас бүх гишүүдийн хуралд биечлэн оролцох боломжгүй бол саналаа бичгээр ирүүлж болно.

33.7.Хадгаламж, зээлийн хоршооны гишүүн нь өөрийн нэрийн өмнөөс бусад этгээдийг итгэмжлэлийн дагуу бүх гишүүдийн хуралд оролцуулж болно. Итгэмжлэлийг нотариатаар гэрчлүүлэх ба итгэмжлэгдсэн этгээд нь бүх гишүүдийн хуралд гишүүний нэгэн адил саналын эрх эдэлнэ.

33.8.Бүх гишүүдийн хурлын зарыг мэдэх боломжтой байсан, эсхүл мэдсэн боловч хуралд ирээгүйгээс үүсэх хариуцлагыг хадгаламж, зээлийн хоршоо, тэргүүлэгчдийн зөвлөл хариуцахгүй.

33.9.Гишүүн нь энэ хуулийн 27.2.5-д заасны дагуу өөрийн оршин суугаа газрын хаягийн өөрчлөлтийг мэдэгдээгүйгээс үүсэх хариуцлагыг тухайн хадгаламж, зээлийн хоршоо, тэргүүлэгчдийн зөвлөл хариуцахгүй.

34 дүгээр зүйл.Бүх гишүүдийн хурлын дэг, хурлын тэмдэглэл

34.1.Бүх гишүүдийн хурлыг тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга, түүний эзгүйд тэргүүлэгчдийн зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгч удирдана.

34.2.Нийт саналын эрхтэй гишүүн бүрт бүх гишүүдийн хурлын зарыг албан ёсоор хүргэсэн байх ба хурлын зарыг хэрхэн хүргэсэн талаар хуралд ирсэн гишүүдэд танилцуулна.

34.3.Бүх гишүүдийн хурлаас хурлын нарийн бичгийн дарга, тооллогын комиссыг сонгоно.

34.4.Бүх гишүүдийн хурлын үйл ажиллагааг хурлын тэмдэглэлээр баталгаажуулах бөгөөд хурлын тэмдэглэлд дараах мэдээллийг заавал тусгана:

34.4.1.бүх гишүүдийн хурал болсон он, сар, өдөр, газар, хугацаа;

34.4.2.бүх гишүүдийн хурлын ирц;

34.4.3.энэ хуулийн 34.2-т заасан гишүүдийн нэр, сонгосон саналын хувь;

34.4.4.бүх гишүүдийн хурлаар хэлэлцсэн асуудлууд;

34.4.5.бүх гишүүдийн хурлын санал хураалтын арга, хэлбэр;

34.4.6.хурлаар хэлэлцсэн асуудалд өгсөн зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн саналын тоог асуудал тус бүрээр гаргах.

34.5.Хурлын тэмдэглэлд тэмдэглэл хөтөлсөн гишүүн болон тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

35 дугаар зүйл.Тэргүүлэгчдийн зөвлөл

35.1.Бүх гишүүдийн хурлын чөлөөт цагт хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааг тэргүүлэгчдийн зөвлөл удирдаж, үйл ажиллагаагаа бүх гишүүдийн хуралд тайлагнана.

35.2.Тэргүүлэгчдийн зөвлөл нь гурваас доошгүй сондгой тооны гишүүдийн бүрэлдэхүүнтэй байх ба тэдгээрийг бүх гишүүдийн хурлаас сонгоно.

35.3.Тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүнээр дор дурдсан шаардлагыг хангасан тухайн хадгаламж, зээлийн хоршооны гишүүнийг сонгоно:

- 35.3.1.зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй;
- 35.3.2.ял шийтгэлгүй;
- 35.3.3.тухайн сонгуульт ажлыг хашихад харшлах зүйлгүй;
- 35.3.4.сүүлийн гурван жилийн хугацаанд санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаад дампуурсан хуулийн этгээдийн удирдлагад ажиллаагүй.
- 35.3.5.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа эсхүл эдийн засгийн гэмт хэрэгтэй холбоотойгоор ял шийтгэл хүлээж байгаагүй.
- 35.4.Хадгаламж, зээлийн хоршооны тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр хувь нь банк, санхүү, эдийн засаг, хуулийн мэргэжилтэй байна.
- 35.5.Тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүнээр хяналтын зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтныг сонгохыг хориглоно.
- 35.6.Тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа гурав хүртэл жил байх бөгөөд дараалан хоёроос дээш удаа сонгохгүй.
- 35.7.Хадгаламж, зээлийн хоршооны тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүнийг нөөц гишүүнтэйгээр сонгох бөгөөд холбогдох харилцааг хоршооны дүрэмд тусгана.
- 35.8.Тэргүүлэгчдийн зөвлөл нь 30 хоногт нэгээс доошгүй удаа хуралдах ба олонхийн саналаар шийдвэр гаргана.
- 35.9.Тэргүүлэгчдийн зөвлөлийн шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх ба тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 35.10.Тэргүүлэгчдийн зөвлөлийн хурлын үйл ажиллагааг тэмдэглэлээр баталгаажуулах бөгөөд тэмдэглэлд хуралд оролцсон гишүүн бүр гарын үсэг зурна.
- 35.11.Тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралд оролцох боломжгүй тохиолдолд хэлэлцэх асуудалтай урьдчилан танилцаж бичгээр санал өгч болно. Энэ тохиолдолд гишүүнийг ирсэнд тооцно.
- 35.12.Тэргүүлэгчдийн зөвлөлийн хуралд гурав буюу түүнээс дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй, хууль, хадгаламж, зээлийн хоршооны дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүнийг тэргүүлэгчдийн зөвлөл эрхийг нь түдгэлзүүлэх ба гишүүнийг нөхөн сонгох хүртэл нөөц гишүүн ажиллана.
- 35.13.Тухайн хадгаламж, зээлийн хоршоонд хугацаа хэтэрсэн зээлийн өртэй тэргүүлэгчдийн зөвлөлөөс бүрэн эрхийг нь түдгэлзүүлсэн тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүн нь тэргүүлэгчдийн зөвлөлийн хуралд саналын эрх эдлэхгүй. 35.14.Тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүн ажил үүргийн хүрээнд авсан мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах үүрэгтэй.
- 35.15.Тэргүүлэгчдийн зөвлөл, түүний гишүүний бүрэн эрх, тэргүүлэгчдийн зөвлөлийн ажиллах зарчмыг хадгаламж, зээлийн хоршооны дүрмээр нарийвчлан тодорхойлно.
- 35.16.Тэргүүлэгчдийн зөвлөл нь хадгаламж, зээлийн хоршооны өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй.

36 дугаар зүйл. Тэргүүлэгчдийн зөвлөлийн бүрэн эрх

- 36.1.Тэргүүлэгчдийн зөвлөл нь дараах бүрэн эрхтэй байна:
- 36.1.1.хадгаламж, зээлийн хоршоог хөгжүүлэх бодлого, бизнес төлөвлөгөөг боловсруулж бүх гишүүдийн хурлаар батлуулах;
- 36.1.2.хууль, хадгаламж, зээлийн хоршооны дүрэм, журмын хэрэгжилтийг нь хангуулах;
- 36.1.3.хадгаламж, зээлийн хоршоо нь үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэхэд хяналт тавих;
- 36.1.4.хадгаламж, зээлийн журмыг батлах, хүүг тогтоох;
- 36.1.5.нягтлан бодох бүртгэлийг хууль тогтоомжийн дагуу хөтлүүлж, жилийн санхүүгийн тайланг хяналтын зөвлөл болон бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэх;
- 36.1.6.жилийн орлогоос алдагдлыг нөхөх, нөөцийн сан, хадгаламж хамгаалалтын болон тогтворжилтын сангийн шимтгэлийг бүрдүүлэх, гишүүдэд хүртээх хувь хөрөнгийн хэмжээний талаар санал боловсруулж, бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах;

36.1.7.жил, улирлын санхүүгийн тайлан болон урьдчилсан тооцоогоор үүсэж болзошгүй алдагдлыг нөөцийн сангийн хөрөнгөөр нөхөх боломжгүй, эсхүл хадгаламж, зээлийн хоршоо нь санхүү, төлбөрийн чадвар муудсан, өөрийн хөрөнгөгүй болсон бол энэ тухай Хороонд мэдэгдэж, бүх гишүүдийн хурлаар уг асуудлыг нэн даруй хэлэлцүүлэх;

36.1.8.бүх гишүүдийн хурлаас баталсан үйл ажиллагааны жилийн төсвийн зарцуулалтад хяналт тавих;

36.1.9.сүүлчийн санхүүгийн тайлангийн нийт активын 10 хувиас дээш хэмжээтэй нэг буюу хоорондоо шууд хамаарал бүхий хэд хэдэн хэлцэл хийх шийдвэр гаргах, ашиг сонирхлын зөрчил бүхий үйлдэлтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх;

36.1.10.Төв хадгаламж, зээлийн хоршоо, тогтворжилтын сангаас зээл, санхүүгийн туслалцаа авах талаар шийдвэр гаргах;

36.1.11.бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах бэлтгэл ажлыг зохион байгуулах;

36.1.12.жилийн эцсийн санхүүгийн тайланг баталгаажуулах аудитын байгууллагыг сонгох;

36.1.13.бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэхээр хадгаламж, зээлийн хоршооны дүрэмд заагаагүй бол шинэ гишүүн элсүүлэх асуудлыг шийдвэрлэх, гишүүний эрхийг түдгэлзүүлэх, идэвхгүй гишүүнд тооцох;

36.1.14.хадгаламж, зээлийн хоршооны гишүүн гишүүнээс гарах тухай өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх;

36.1.15.энэ хуулийн 25 дугаар зүйлд заасан этгээдтэй зохих журмын дагуу тооцоо хийх;

36.1.16.гишүүний бүртгэлийг хөтлөх, холбогдох өөрчлөлтийг тухай бүрд хийж, гишүүдийн тоо хуулиар тогтоосон доод хязгаарт хүрэхгүй болсон тохиолдолд энэ талаар Хороонд мэдэгдэж зохих арга хэмжээг авах;

36.1.17.Зээлийн хороо болон бусад хороог байгуулах, тэдгээрийн гишүүдийг томилох, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

36.1.18.гүйцэтгэх захирлыг томилох, түүнтэй гэрээ байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавих;

36.1.19.үүсгэн байгуулах хурлаас үүсгэн байгуулах тухай шийдвэр гарсны дараа тухайн хадгаламж, зээлийн хоршоог хуулийн этгээдийн улсын бүртгэлд шинээр бүртгүүлэх, өөрчлөлт гарсан тухай бүр холбогдох өөрчлөлтийг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлж, Хороонд мэдээлэх;

36.1.20.хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гишүүнчлэл бүхий гүйцэтгэх захирал, ажилтанд зээл олгох зөвшөөрлийг олгох, зээлийн гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;

36.1.21.хуулиар бүх гишүүдийн хурал, хяналтын зөвлөлийн эрх хэмжээнд хамааруулснаас бусад асуудлыг авч хэлэлцэх, шийдвэр гаргах;

36.1.22.төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангах зорилгоор банк, банк бус санхүүгийн байгууллага, эсхүл төсөл, хөтөлбөрийн хүрээнд богино хугацаатай хөрөнгийн эх үүсвэрийг зохистой харьцааны шалгуур үзүүлэлтэд заасан хэмжээнээс хэтрүүлэхгүй авах шийдвэр гаргах;

36.1.23.хууль, дүрэмд заасан бусад асуудал.

37 дугаар зүйл.Хяналтын зөвлөл

37.1.Хяналтын зөвлөл нь хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа бүх гишүүдийн хуралд тайлагнана.

37.2.Хяналтын зөвлөл нь гурваас доошгүй сондгой тооны гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба зөвлөлийн гишүүдийг бүх гишүүдийн хурлаас сонгоно. Сонгогдсон гишүүдээс хяналтын зөвлөлийн даргыг сонгоно.

37.3.Хяналтын зөвлөлийн гишүүнд энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан шаардлага нэг адил хамаарна.

37.4.Хяналтын зөвлөлийн гишүүн нь тэргүүлэгчдийн зөвлөл, зээлийн хороо, гүйцэтгэх захирал, ажилтан байхыг хориглоно.

37.5.Хяналтын зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа гурав хүртэл жил байх бөгөөд дараалан хоёроос дээш удаа сонгохгүй.

37.6.Хадгаламж, зээлийн хоршооны хяналтын зөвлөлийн гишүүнийг нөөц гишүүнтэйгээр сонгоно.

37.7.Хяналтын зөвлөлийн хуралд гурав буюу түүнээс дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр оролцоогүй, хууль, хадгаламж, зээлийн хоршооны дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй хяналтын зөвлөлийн гишүүнийг хяналтын зөвлөл эрхийг нь түдгэлзүүлэх ба гишүүнийг нөхөн сонгох хүртэл нөөц гишүүн ажиллана.

37.8.Хяналтын зөвлөл нь улиралд хоёроос доошгүй удаа хуралдана.

37.9.Хяналтын зөвлөлийн хурал нь гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөр болно.

37.10.Хяналтын зөвлөл нь хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэр гаргах ба тухайн шийдвэрт дэмжсэн санал өгсөн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

37.11.Хяналтын зөвлөлийн хурлын үйл ажиллагааг тэмдэглэлээр баталгаажуулах бөгөөд оролцсон гишүүд гарын үсэг зурна.

37.12.Хяналтын зөвлөлийн гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралд оролцох боломжгүй тохиолдолд хэлэлцэх асуудалтай урьдчилан танилцаж бичгээр санал өгч болно. Энэ тохиолдолд гишүүнийг ирсэнд тооцно.

37.13.Хяналтын зөвлөлийн гишүүн ажил үүргийн хүрээнд авсан мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах үүрэгтэй.

37.14.Тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн гишүүдийн олонх нь хяналтын зөвлөлийг хуралдуулах тухай санал гаргасан, эсхүл хяналтын зөвлөлийн дарга шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хяналтын зөвлөлийн хурлыг хэдийд ч зарлан хуралдуулж болно.

38 дугаар зүйл.Хяналтын зөвлөлийн бүрэн эрх

38.1 Хяналтын зөвлөл нь дараах бүрэн эрхтэй байна:

38.1.1.тэргүүлэгчдийн зөвлөл, зээлийн хороо, гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд хяналт тавих, Хороо, бүх гишүүдийн хурал, тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлөөс өгсөн үүрэг даалгавар, шийдвэрийн биелэлтийг хангуулах;

38.1.2.хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаатай холбоотой шаардлагатай баримт бичиг, тайлан, мэдээлэлтэй танилцах;

38.1.3.хадгаламж, зээлийн хоршооны бодлогын хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн биелэлтэд хяналт тавих, дүгнэлт гаргаж бүх гишүүдийн хуралд танилцуулах;

38.1.4.жил, улирлын санхүүгийн тайлан, тухайн жилийн орлого хуваарилалт, алдагдлыг нөхөх зэрэг асуудлаар санал дүгнэлт гаргаж, бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэх;

38.1.5.хяналтын зөвлөл нь гүйцэтгэх захирлын эрхийг түдгэлзүүлэх тухай саналаа тэргүүлэгчдийн зөвлөлд оруулах, тэргүүлэгчдийн зөвлөл хуралдах боломжгүй бол гүйцэтгэх захирлын эрхийг түр түдгэлзүүлэх;

38.1.6.шаардлагатай гэж үзвэл бүх гишүүдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;

38.1.7.тэргүүлэгчдийн зөвлөл, зээлийн хороо, гүйцэтгэх захирлын үйл ажиллагаа нь хууль бус, тухайн хадгаламж, зээлийн хоршоо, гишүүдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр бол уг үйл ажиллагааг таслан зогсоох, гаргасан шийдвэрийг хүчингүй болгох, залруулга хийхийг шаардах;

38.1.8.хууль тогтоомж, дүрэм, журмыг зөрчсөн тэргүүлэгчдийн зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтанд сануулга өгөх, шаардлагатай гэж үзвэл эрх бүхий дээд шатны байгууллага, албан тушаалтанд зохих хариуцлага тооцуулахаар санал тавих;

38.1.9.тэргүүлэгчдийн зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гишүүнчлэл бүхий гүйцэтгэх захирал болон ажилтанд зээл олгох ажиллагаанд хяналт тавих, тэргүүлэгчдийн зөвлөлийн гишүүнд зээл олгох асуудлыг шийдвэрлэх;

38.1.10.хяналтын зөвлөл болон эрх бүхий бусад байгууллагын эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэрийг тэргүүлэгчдийн зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал болон ажилтан биелүүлээгүйгээс хадгаламж, зээлийн хоршоо, гишүүдэд хохирол учруулсан бол уг асуудлаар хадгаламж, зээлийн хоршооны нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах, шүүх ажиллагаанд оролцох;

38.1.11.тэргүүлэгчдийн зөвлөлийн болон зээлийн хорооны хуралд саналын эрхгүй оролцох;

38.1.12.шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн шинжээчийг төлбөртэй ажиллуулах;

38.1.13.хадгаламж, зээлийн хоршооны дүрмээр тогтоосон бусад бүрэн эрх.

39 дүгээр зүйл.Зээлийн хороо

39.1.Хадгаламж, зээлийн хоршоо нь зээлийн хороотой байна.

39.2.Зээлийн хороог тэргүүлэгчдийн зөвлөл гурваас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулах ба зээлийн хороо нь үйл ажиллагаагаа тэргүүлэгчдийн зөвлөлд тайлагнана.

39.3.Зээлийн хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй хувь нь банк, санхүү, эдийн засаг, хуулийн мэргэжилтэй байна.

39.4.Зээлийн хорооны гишүүнд 35.3, 35.4-д заасан шаардлага нэгэн адил хамаарах бөгөөд зээлийн хорооны гишүүн нь тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн гишүүн байж болохгүй.

39.5.Зээлийн хорооны хуралдах хугацааг хадгаламж, зээлийн хоршооны дүрэмд нарийвчлан заах ба зээлийн хорооны хуралд гишүүдийн олонх нь оролцсоноор хүчин төгөлдөр болно.

39.6.Зээлийн хороо нь шийдвэрээ хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар гаргах ба гарсан шийдвэрийг дэмжсэн санал өгсөн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.

39.7.Зээлийн хороо дараах бүрэн эрхтэй байна:

39.7.1.хадгаламж, зээлийн хоршооны дүрэмд өөрөөр заагаагүй бол зээлийн бодлогыг хэрэгжүүлэх, тэргүүлэгчдийн зөвлөлд санал оруулах;

39.7.2.хадгаламж, зээлийн хоршооны дүрэмд өөрөөр заагаагүй бол зээл авахаар ирүүлсэн хүсэлтийг хүлээн авах, хянах, олгох эсэх асуудлыг шийдвэрлэх, зээлийн гэрээ байгуулах;

39.7.3.зээлийн эргэн төлөлтөд хяналт тавих;

39.7.4.шаардлагатай гэж үзвэл бүх гишүүдийн хурлыг хуралдуулах саналыг тэргүүлэгчдийн зөвлөлд гаргах;

38.7.5.хууль болон хадгаламж, зээлийн хоршооны дүрмээр тогтоосон бусад бүрэн эрх.

39.8.Зээлийн хорооны гишүүн ажил үүргийн хүрээнд авсан мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах үүрэгтэй.

40 дүгээр зүйл.Гүйцэтгэх захирал

40.1.Гүйцэтгэх захирал нь хадгаламж, зээлийн хоршооны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

40.2.Гүйцэтгэх захирлыг тэргүүлэгчдийн зөвлөлөөс томилж, гэрээ байгуулах ба үйл ажиллагаагаа тэргүүлэгчдийн зөвлөлд тайлагнана.

40.3.Гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин хөлс, урамшуулал зэргийг тусгана.

40.4.Тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн гишүүн гүйцэтгэх захирлаар ажиллахыг хориглоно.

40.5.Хадгаламж, зээлийн хоршооны дүрэмд өөрөөр заагаагүй бол гүйцэтгэх захирал нь тухайн хадгаламж, зээлийн хоршооны гишүүнчлэлгүй байж болно.

40.6.Гүйцэтгэх захирал нь дараах шаардлагыг хангасан байна:

40.6.1.банк, санхүү, эдийн засаг, хуулийн мэргэжилтэй;

40.6.2.Зээл, батлан даалт, гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй;

40.6.3.ял шийтгэлгүй;

40.6.4.мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа, эсхүл эдийн засгийн гэмт хэрэгтэй холбоотойгоор ял шийтгэл хүлээж байгаагүй;

40.6.5.тухайн албан тушаалыг хашихад харшлах зүйлгүй;

40.6.6.сүүлийн гурван жилийн хугацаанд санхүүгийн зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаад дампуурсан хуулийн этгээдийн удирдлагад ажиллаагүй.

40.7.Гүйцэтгэх захирал дараах бүрэн эрхтэй байна:

40.7.1.тэргүүлэгчдийн зөвлөлөөс эрх олгосноор гадаад, дотоод харилцаанд хадгаламж, зээлийн хоршоог төлөөлөх;

40.7.2.ажилтныг томилох, чөлөөлөх, ажлаас халах, түүнтэй гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих;

40.7.3.хадгаламж, зээлийн хоршооны нэрийн өмнөөс иргэний эрх зүйн харилцаанд оролцох;

40.7.4.сүүлийн санхүүгийн тайлангаар баталгаажсан нийт активын 10 хувиас доош хэмжээтэй нэг буюу хоорондоо шууд хамаарал бүхий хэд хэдэн хэлцэл хийх шийдвэр гаргах.

40.8.Гүйцэтгэх захирал нь энэ хуулийн 36.1.7-д заасан нөхцөл байдал бий болсон тохиолдолд энэ талаар тэргүүлэгчдийн зөвлөл болон Хороонд нэн даруй мэдэгдэж цаашид авах арга хэмжээний талаарх санал гаргах үүрэгтэй.

40.9.Хадгаламж, зээлийн хоршооны гүйцэтгэх захирал, ажилтан нь бусад хадгаламж, зээлийн хоршоонд давхар ажиллахыг хориглоно.

40.10.Гүйцэтгэх захирал нь ажил үүргийн хүрээнд авсан мэдээллийн нууцлалыг чандлан хадгалах үүрэгтэй.

41 дүгээр зүйл.Тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтны хүлээх хариуцлага

41.1.Тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтан нь хадгаламж, зээлийн хоршооны хөрөнгийг хувийн хэрэгцээнд ашигласан, түүний буруутай үйл ажиллагааны улмаас хадгаламж, зээлийн хоршоонд учруулсан хохирлыг буруутай этгээд өөрийн хувийн өмчийн хөрөнгөөр хариуцна.

41.2.Хадгаламж, зээлийн хоршоонд учруулсан хохирлыг нөхөн төлөхөөс зайлсхийх зорилгоор, эсхүл хууль бус үйлдлээ халхавчлах үүднээс олсон ашиг, орлого, эд хөрөнгөө бусдын өмчлөлд буюу хамтран өмчлөх дундын эд хөрөнгөд шилжүүлсэн нь нотлогдвол тэр хэмжээгээр тухайн эд хөрөнгөөс нөхөн гаргуулна.

41.3.Тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтан нь бүх гишүүдийн хурлын шийдвэр, тус бүрийн дээд шатны байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр нь хадгаламж, зээлийн хоршоо болон гишүүдэд хохирол учруулж болзошгүйг мэдэж байсан, эсхүл мэдэх боломжтой байсан боловч уг шийдвэрийг хэрэгжүүлснээс үүссэн хохирлыг нөхөн төлөх хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

41.4.Тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтан нь хууль бус болон хадгаламж, зээлийн хоршоо болон гишүүдэд хохирол учруулж болзошгүй гэж үзсэн, шийдвэрийг эс зөвшөөрсөн, тухайн шийдвэр гарахад оролцоогүй, эсхүл эсрэг санал өгсөн нь баримтаар нотлогдож байгаа бол учирсан хохирлыг хариуцахгүй.

42 дугаар зүйл. Тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүд, гүйцэтгэх захирал, ажилтны хүлээх үүрэг

42.1. Тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтан нь бүх гишүүдийн хурлын шийдвэр, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэр нь хууль бус болон хадгаламж, зээлийн хоршоо, гишүүдэд хохирол учруулж болзошгүй шийдвэрийн талаар мэдсэн, мэдэх ёстой байсан өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор Хороонд бичгээр мэдэгдэх үүрэгтэй бөгөөд эсрэг саналаа тухайн шийдвэрийг гаргаж байгаа хурлын тэмдэглэлд тэмдэглүүлэх үүрэгтэй.

42.2. Энэ хуулийн 41.1-д заасан тохиолдолд эсрэг саналаа тухайн шийдвэрийг гаргаж байгаа хурлын тэмдэглэлд тэмдэглүүлнэ.

42.3. Тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтан нь тухайн хадгаламж, зээлийн хоршооны нууц мэдээллийг чандлан хадгалах, ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх үүрэгтэй.

43 дугаар зүйл. Ашиг сонирхлын зөрчил бүхий үйлдэл

43.1. Тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүн, үүсгэн байгуулагч гишүүн, гүйцэтгэх захирал, ажилтан нь хашиж буй албан тушаалаас хамааран аливаа давуу байдал, эсхүл хөнгөлөлт эдлэхгүй.

43.2. Хадгаламж, зээлийн хоршооны тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөл, зээлийн хорооны гишүүд, гүйцэтгэх захирал, ажилтан, гишүүний зүгээс өөрт нь, эсхүл тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдэд ашигтай буюу илт давуу байдал тогтоох зорилгоор хийсэн, хоршооны эрх ашигт сөргөөр нөлөөлөх үйлдэл /эс үйлдэхүй/ илэрвэл тухайн этгээд энэ тухай тэргүүлэгчдэд бичгээр мэдэгдэж, уг асуудлаар шийдвэр гаргах, гэрээ, хэлцэл байгуулахаас татгалзах үүрэгтэй.

43.3. Энэ хуулийн 43.2-д заасныг зөрчиж хийсэн ашиг сонирхлын зөрчил бүхий шийдвэр, гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

43.4. Энэ хуулийн 43.2-д заасан үйлдэл /эс үйлдэл/-ийн улмаас хадгаламж, зээлийн хоршоонд учирсан хохирлыг гэм буруутай этгээд бүрэн хариуцна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ӨӨРИЙН ХӨРӨНГӨ, САНХҮҮГИЙН ТАЙЛАН

44 дүгээр зүйл. Өөрийн хөрөнгө

44.1. Хадгаламж, зээлийн хоршоо нь өөрийн хөрөнгөд гарсан өөрчлөлт болон гишүүдийн тоонд орсон өөрчлөлтийн талаар хагас, бүтэн жилээр Хороонд мэдэгдэнэ.

45 дугаар зүйл. Гишүүний оруулсан хувь хөрөнгө, жилийн орлогоос хувь хүртэх

45.1. Хадгаламж, зээлийн хоршооны гишүүн нь тухайн хадгаламж, зээлийн хоршоонд оруулах хувь хөрөнгийг дүрэмд заасан хэмжээгээр оруулна.

45.2. Хадгаламж, зээлийн хоршооноос гишүүдэд хүртээх хувь хөрөнгийг зөвхөн тухайн жилийн цэвэр орлогоос хадгаламж, зээлийн хоршооны дүрэмд заасан хэмжээгээр нөөцийн санг бүрдүүлсний дараа хуваарилж болно.

45.3. Тухайн жилд гишүүдэд хүртээх хөрөнгийн хэмжээг бүх гишүүдийн хурал тогтооно.

45.4. Тэргүүлэгчдийн зөвлөл гишүүдийн оруулсан хувь хөрөнгийн бүртгэлийг хөтөлнө.

46 дугаар зүйл. Хадгаламж, зээлийн хоршооны идэвхгүй гишүүний хөрөнгө

46.1. Гишүүн нь дараалсан 12 буюу түүнээс дээш сарын хугацаанд тухайн хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд ямар нэг хэлбэрээр оролцоогүй бол уг гишүүнийг

тэргүүлэгчдийн зөвлөлийн шийдвэрээр идэвхгүй гишүүнд тооцож, гишүүний эрхийг түдгэлзүүлж болно.

46.2.Тэргүүлэгчдийн зөвлөл нь идэвхгүй гишүүнээр тооцох тухай шийдвэр гаргахаас ажлын 30 өдрийн өмнө тухайн гишүүнд бичгээр мэдэгдэнэ.

46.3.Энэ хуулийн 46.2-т заасан мэдэгдлийг хүлээн авах боломжтой байсан, эсхүл хүлээн авсан боловч ажлын 15 өдрийн дотор хариу тайлбар ирүүлээгүй гишүүнийг идэвхгүй гишүүнд тооцож, түүний оруулсан хувь хөрөнгөтэй дүйцэх хөрөнгө, хадгаламжийн үлдэгдэл, тухайн жилийн орлогоос хүртэх хувь хөрөнгө, хүүгийн төлбөр зэргийг тусгайлсан дансанд төвлөрүүлж, санхүүгийн тайлан, мэдээнд тусгайлан тусгана.

46.4.Энэ хуулийн 46.1-д заасны дагуу идэвхгүй гишүүнд тооцох тухай тэргүүлэгчдийн шийдвэр гарсан өдрөөс хойш тухайн гишүүний оруулсан хувь хөрөнгөд ногдох хувь хуваарилахгүй, хадгалуулсан мөнгөн хөрөнгөд нь хүү тооцохгүй.

46.5.Энэ хуулийн 46.1-д заасны дагуу идэвхгүй гишүүнээр тооцогдсон гишүүнийг тухайн хадгаламж, зээлийн хоршооны гишүүнээс хассан тухай шийдвэрийг эс зөвшөөрвөл тухайн гишүүн энэ тухай шийдвэрийг бүх гишүүдийн хурлаар заавал хэлэлцүүлэх бөгөөд бүх гишүүдийн хурлын шийдвэр гарах хүртэлх хугацаанд тухайн гишүүн хүсвэл тэргүүлэгчдийн зөвлөлд хүсэлт гаргаж, гишүүний эрхээ сэргээлгэж болно.

46.6.Идэвхгүй гишүүнтэй хийх төлбөр тооцоог энэ хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу хийж гүйцэтгэнэ.

47 дугаар зүйл. Санхүүгийн тайлан

47.1.Хадгаламж, зээлийн хоршооны санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Хорооноос баталсан нягтлан бодох бүртгэлийн журамд нийцсэн байна.

47.2.Хадгаламж, зээлийн хоршоо нь санхүүгийн тайлангаа улирал, жилээр гаргаж тогтоосон хугацаанд Хороонд хүргүүлнэ. Хороо нь тухайн хадгаламж, зээлийн хоршооны санхүүгийн тайлантай холбогдсон нэмэлт нотлох баримтыг шаардах эрхтэй.

47.3.Хадгаламж, зээлийн хоршоо нь сар /улирал, жил/-ын давтамжтай санхүүгийн нэмэлт мэдээллийг ирүүлнэ. Мэдээллийн маягтыг Хороо батална.

47.4.Санхүүгийн тайлан дахь үзүүлэлт, тоон мэдээлэл буруу, алдаатай, эсхүл зохих журмыг зөрчиж гаргасан бол холбогдох зөрчлийг арилгах, залруулга хийхийг Хороо тухайн хадгаламж, зээлийн хоршооноос шаардаж болно.

47.5.Хадгаламж, зээлийн хоршоо нь аудитаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайланг Хорооноос тогтоосон журмын дагуу эхний хагас жилд багтаан нийтэд мэдээлнэ.

48 дугаар зүйл. Санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулах

48.1.Хадгаламж, зээлийн хоршоо нь санхүүгийн тайлангаа тэргүүлэгчдийн зөвлөлийн сонгосон, Хорооноос эрх олгосон аудитын байгууллагаар жилд нэгээс доошгүй удаа шалгуулж баталгаажуулна.

48.2.Аудитын байгууллага нь санхүүгийн тайланг баталгаажуулсан дүгнэлтийг хадгаламж, зээлийн хоршооны тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлд танилцуулна.

48.3.Эрх олгосон аудитын байгууллагын жагсаалт болон түүнд орсон өөрчлөлтийг Хорооноос тухай бүр нийтэд мэдээлнэ.

48.4.Хадгаламж, зээлийн хоршоо нь аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг дараах баримт бичгийн хамт 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ:

48.4.1. удирдлагын тайлан;

48.4.2. аудитын дүгнэлт;

48.4.3. тухайн санхүүгийн жилийн үйл ажиллагааны тайлан, холбогдох тодруулга, тайлбар;

48.4.4. бусад холбогдох баримт бичиг.

48.5.Энэ хуулийн 48.4-д заасан баримт бичгийн бүрдэл дутуу тохиолдолд санхүүгийн тайланг ирүүлээгүйд тооцно.

50 дугаар зүйл. Санхүүгийн үйлчилгээний мэдээлэл хүргэх

50.1.Хадгаламж, зээлийн хоршоо нь оноосон нэр, эрх бүхий байгууллагаас эрхлэхийг зөвшөөрсөн ажил, үйлчилгээний талаарх мэдээллийг өөрийн үйл ажиллагаа эрхлэн явуулах байранд хэрэглэгчид харагдахуйц байдлаар тавина.

50.2.Хэрэглэгчтэй гэрээ байгуулах зэргээр аливаа харилцаа үүсгэхийн өмнө хадгаламж, зээлийн хоршоо нь тухайн санхүүгийн ажил, үйлчилгээний нөхцөл, шаардлагын талаар, үйлчилгээний төлбөрийн талаар, үргэлжлэх хугацааны талаар болон үүсч болзошгүй үр дагаврын талаарх хэрэглэгчийн шийдвэрт нөлөөлөхуйц мэдээллийг дэлгэрэнгүйгээр өгөх үүргийг хүлээнэ.

50.3.Хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон бусад харилцааг Хорооноос баталсан журмаар зохицуулна.

ДОЛДУГААР БҮЛЭГ ТӨВ ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШОО

51 дүгээр зүйл. Төв хадгаламж, зээлийн хоршоо

51.1.Төв хадгаламж, зээлийн хоршоо /цаашид “Төв ХЗХ” гэх/ нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлсэн Хорооноос олгосон тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд байна.

51.2. Төв ХЗХ нь Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулах бөгөөд тусгай зөвшөөрөл бүхий хадгаламж, зээлийн хоршоод заавал гишүүнчлэлтэй байна.

51.3.Төв ХЗХ-нд тусгай зөвшөөрөл бүхий хадгаламж, зээлийн хоршооноос бусад иргэн, хуулийн этгээд гишүүнээр элсэхийг хориглоно.

51.4.Төв ХЗХ нь энэ хуулийн 29.1-д заасан хадгаламж, зээлийн хоршооны үндсэн бүтцээс гадна чиг үүргийн зөвлөл, хороо, сургалтын төвтэй байж болно.

51.5.Төв ХЗХ-ны удирдлага болон үйл ажиллагаанд тавигдах нөхцөл шаардлага, үйл ажиллагааг нь зохицуулахтай холбогдсон дүрэм, журмыг Хороо баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

51.6.Сонгуульт албан тушаалтнууд нь Төв ХЗХ-нд давхар сонгуульт болон гүйцэтгэх албан тушаал эрхлэхийг хориглоно.

51.7.Төв ХЗХ-г дарга, эсхүл түүний эрх олгосон гүйцэтгэх захирал төлөөлнө.

51.8.Төв ХЗХ нь санхүүгийн тайлангаа улирал, жилээр гаргаж тогтоосон хугацаанд Хороонд хүргүүлнэ.

51.9.Төв ХЗХ-г үүсгэн байгуулах, тусгай зөвшөөрөл олгох, салбар байгуулах зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг хүчингүй болгох, татан буулгахтай холбогдох харилцааг Хорооноос баталсан журмаар зохицуулна.

52 дугаар зүйл. Төв хадгаламж, зээлийн хоршоог үүсгэн байгуулах

52.1.Төв ХЗХ-г тодорхой бус хугацаагаар үүсгэн байгуулах бөгөөд тусгай зөвшөөрлийг Хорооноос олгоно.

52.2.Төв ХЗХ-г нийт хадгаламж, зээлийн хоршоодын 51-ээс доошгүй хувь нь энэ хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу үүсгэн байгуулж, холбогдох баримт бичгийг Хороонд ирүүлнэ.

52.3.Хороо баримт бичгийг хүлээн авснаас хойш 45 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлыг хянаж, шийдвэрлэнэ.

52.4.Хороо нь Төв ХЗХ-г үүсгэн байгуулах өргөдөл зөвшөөрөл олгосон эсэх тухай улсын бүртгэлийн байгууллагад бичгээр мэдэгдэнэ.

53 дугаар зүйл. Төв хадгаламж, зээлийн хоршооны дүрэм

53.1. Төв ХЗХ-ны дүрэм нь түүний үйл ажиллагааг зохицуулах үндсэн баримт бичиг байна.

53.2. Төв ХЗХ нь хууль тогтоомжид нийцсэн, Хорооноос зөвшөөрсөн дүрэмтэй байна.

54 дүгээр зүйл. Төв хадгаламж, зээлийн хоршооны бүх гишүүдийн хурал, бүрэн эрх

54.1. Бүх гишүүдийн хурал хуралдуулах, хурлын дэг, хурлын ирц, хурлаас гарах тэмдэглэл, шийдвэр, холбогдох харилцааг Төв ХЗХ-ны дүрмээр зохицуулна.

54.2. Бүх гишүүдийн хурал нь энэ хуулийн 30 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

54.2.1. Төв ХЗХ-ны дүрмийг батлах, нэмэлт өөрчлөлт оруулах;

54.2.2. жилийн төсвийг батлах;

54.2.3. гишүүнчлэлийн татвар, хураамжийн хэмжээг тогтоох;

54.2.4. Төв ХЗХ-ноос үзүүлэх тогтворжилтын үйлчилгээний хэмжээг тогтоох;

54.2.5. тогтворжилтын сангийн заавал байх нөөцийн доод хэмжээг тогтоох;

54.2.6. өмч хөрөнгийг захиран зарцуулах талаар тэргүүлэгчдийн зөвлөлийн эрх, хэмжээг тогтоох;

54.2.7. тогтворжилтын сангийн зөвлөл болон чиг үүргийн бусад хороог байгуулах;

54.2.8. тогтворжилтын үйлчилгээний талаар шийдвэр гаргах эрх, хэмжээг тодорхойлох;

54.2.9. дүрэмд заасан бусад бүрэн эрх.

55 дугаар зүйл. Төв хадгаламж, зээлийн хоршооны тэргүүлэгчдийн зөвлөл, бүрэн эрх

55.1. Тэргүүлэгчдийн зөвлөл нь гишүүн хадгаламж, зээлийн хоршоодын 5 буюу түүнээс дээш сондгой тооны гишүүдийн төлөөллөөс бүрдэнэ.

55.2. Тэргүүлэгчдийн зөвлөлийн дарга нь Төв ХЗХ-ны дарга байна.

55.3. Тэргүүлэгчдийн зөвлөл нь энэ хуулийн 36 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

55.3.1. хөрөнгө оруулалтын зөвлөлийн үйл ажиллагааг зохицуулах журмыг баталж, мөрдүүлэх;

55.3.2. Төв ХЗХ-ны гүйцэтгэх албаны бүтэц, орон тоог тогтоох;

55.3.3. сангуудыг удирдахтай холбоотой бодлого тодорхойлох;

55.3.4. дүрэмд заасан бусад бүрэн эрх.

56 дугаар зүйл. Төв хадгаламж, зээлийн хоршооны хяналтын зөвлөл, бүрэн эрх

56.1. Хяналтын зөвлөл нь гишүүн хадгаламж, зээлийн хоршоодын тав буюу түүнээс дээш сондгой тооны гишүүдийн төлөөллөөс бүрдэнэ.

56.2. Хяналтын зөвлөл нь энэ хуулийн 38 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

56.2.1. тогтворжилтын үйлчилгээ гишүүн хадгаламж, зээлийн хоршоодод ил тод, хүрч байгаа эсэхэд хяналт тавих, дүгнэлт гаргах;

56.2.2. Төв ХЗХ-ны дүрэмд заасан бусад бүрэн эрх.

57 дугаар зүйл. Төв хадгаламж, зээлийн хоршооны гүйцэтгэх алба, чиг үүргийн хороо

57.1. Төв ХЗХ-ны гүйцэтгэх алба нь үйл ажиллагааны чиг үүргийн дагуу байгуулагдсан хороо, дэд хороодтой байна. Хороодын үйл ажиллагааг гүйцэтгэх захирал удирдан чиглүүлнэ.

57.2. Төв ХЗХ нь үйл ажиллагааны чиг үүргийн дагуу хороо, дэд хороотой байна.

57.3. Чиг үүргийн хороо байгуулах, түүний үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Төв ХЗХ-ны дүрэмд заана.

57.4. Чиг үүргийн хороо нь үйл ажиллагаагаа Тэргүүлэгчдийн зөвлөлд хагас, бүтэн жилээр тайлагнана.

58 дугаар зүйл. Төв хадгаламж, зээлийн хоршооны гүйцэтгэх захирал

58.1. Гүйцэтгэх захирлыг энэ хуулийн 36.1.18-д заасны дагуу томилж, чөлөөлнө. Гүйцэтгэх захирал нь бусад хадгаламж, зээлийн хоршоонд сонгуульт болон гүйцэтгэх албан тушаал хашихгүй.

58.2. Гүйцэтгэх захирал ажлаа тэргүүлэгчдийн зөвлөлд тайлагнана.

58.3. Гүйцэтгэх захирлын эрх, үүргийг Төв ХЗХ-ны дүрэмд заана.

59 дүгээр зүйл. Төв хадгаламж, зээлийн хоршооны хөрөнгийн эх үүсвэр

59.1. Төв ХЗХ-ны хөрөнгө нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

59.1.1. хадгаламж, зээлийн хоршооны оруулах хувь хөрөнгө, гишүүний татвар;

59.1.2. хандив;

59.1.3. зээл;

59.1.4. төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор олгосон санхүүжилт;

59.1.5. хоршоодын төвлөрүүлсэн хадгаламжийн эх үүсвэр;

59.1.6. тогтворжилтын сангийн хөрөнгө.

59.2. Гишүүдийн оруулах хувь хөрөнгийн хэмжээг Төв ХЗХ-ны дүрмээр тогтооно.

60 дугаар зүйл. Төв хадгаламж, зээлийн хоршооны чиг үүрэг

60.1. Төв ХЗХ нь гишүүн хадгаламж, зээлийн хоршоодын санхүүгийн тогтвортой байдлыг хангахад туслэх зорилгоор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

60.1.1. гишүүн хоршоодын санхүүгийн байдал, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, төлбөр түргэн гүйцэтгэх чадварт судалгаа хийж, гарч болзошгүй эрсдэлээс сэргийлэх, таслан зогсоох, хохирлыг багасгах чиглэлээр мэргэжил, арга зүйн зөвлөмж өгөх;

60.1.2. гишүүн хадгаламж, зээлийн хоршоодын хүний нөөцийг бэлтгэх асуудлаар нэгдсэн бодлого боловсруулах, сургах, давтан сургах ажлыг зохион байгуулах;

60.1.3. гишүүн хоршоодоос хадгаламж татан төвлөрүүлэх, тэдэнд зээл олгох үйлчилгээг үзүүлэх;

60.1.4. хадгаламж, зээлийн хоршооны салбарын хөгжлийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

60.1.5. тогтворжилтын үйлчилгээ үзүүлэх;

60.1.6. гишүүн хадгаламж, зээлийн хоршоодод мэдээллийн технологи, маркетингийн нэгдсэн үйлчилгээ үзүүлэх;

60.1.7. цахим төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, удирдах;

60.1.8. Төв ХЗХ-ны сул хөрөнгийг өсгөх зорилгоор Хорооноос зөвшөөрсөн хөрөнгө оруулалт хийх;

60.1.9. гишүүн хоршоодын чадавхыг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн аливаа төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

60.1.10. хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа.

61 дүгээр зүйл. Төв ХЗХ-ны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагнал, аудит

61.1. Төв ХЗХ-нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн Хорооноос баталсан нягтлан бодох бүртгэлийн журмын дагуу улирал бүр санхүүгийн тайланг ирүүлнэ.

61.2.Санхүүгийн жил дууссанаас хойш 6 сарын дотор санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулж, бүх гишүүдийн хуралд танилцуулна. Бүх гишүүдийн хурал нь аудитлагдаагүй санхүүгийн тайланг хэлэлцэхгүй.

61.3.Санхүүгийн тайланд аудит хийх компанийг тэргүүлэгчдийн зөвлөл сонгоно.

62 дугаар зүйл. Төв ХЗХ-ны тогтворжилтын сан

62.1.Төв ХЗХ нь гишүүн хадгаламж, зээлийн хоршоодын төлбөрийн чадварыг сэргээх, тогтвортой байдлыг хангах зорилгоор энэ хуулийн дагуу тогтворжилтын санг байгуулна.

62.2.Төв ХЗХ-ны гишүүн хадгаламж зээлийн хоршоод нь Төв ХЗХ-ны бүх гишүүдийн хурлаас тогтоосон хэмжээгээр тогтворжилтын санд хураамж төлнө. Төв ХЗХ-ны гишүүн хадгаламж, зээлийн хоршооны тогтворжилтын санд төлсөн хураамжийг тухайн хадгаламж, зээлийн хоршооны зардал гэж үзнэ.

62.3.Тогтворжилтын сан нь дараах хөрөнгөөс бүрдэнэ. Үүнд:

62.3.1.гишүүн хадгаламж, зээлийн хоршоодоос жил бүр төвлөрүүлэх хураамж;

62.3.2.тогтворжилтын сангийн сул хөрөнгийг Засгийн газрын болон төвбанкны үнэт цаасанд хөрөнгө оруулалт хийж, түүнээс олсон өгөөж буюу орлого;

62.3.3.Тогтворжилтын сангийн үйл ажиллагааны ашгаас нэмэгдсэн хөрөнгө;

62.3.4.тогтворжилтын сангаас гишүүн хадгаламж, зээлийн хоршоодод олгосон хөрөнгийн эргэн төлөлттэй холбоотойгоор барагдуулаагүй өр төлбөрт хурааж авсан актив хөрөнгө;

62.3.5.иргэн, хуулийн этгээд, олон улсын байгууллагаас хүлээн авсан хандив, тусламжийн хөрөнгө.

62.4.Тогтворжилтын сангийн хөрөнгө нь бусад сангийн хөрөнгөөс тусдаа байх ба санхүүгийн болон санхүүгийн бус үйлчилгээ үзүүлэхэд зарцуулагдана.

62.5.Тогтворжилтын сан нь гишүүддээ тогтворжилтын үйлчилгээ үзүүлэхэд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

62.5.1.түр хугацаанд төлбөрийн чадваргүй болсон, эсхүл төлбөрийн чадваргүй болж болзошгүй хадгаламж, зээлийн хоршооны санхүүгийн байдлыг тогтворжуулах зорилгоор санхүүгийн туслалцаа үзүүлэх;

62.5.2.хадгаламж, зээлийн хоршооны зээл, хадгаламжийн багц, өр төлбөр, эрсдэлийн түвшин, тогтвортой байдалд хяналт хийх;

62.5.3.хадгаламж, зээлийн хоршооны төлбөрийн чадварыг сайжруулах, хадгаламж, зээлийн хоршоонд байгаа санхүүгийн нөөцийг ашиглах удирдамжаар хангаж, зөвлөх үйлчилгээг үзүүлэх;

62.5.4.санхүүгийн туслалцаа хүссэн хадгаламж, зээлийн хоршооны санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх тогтворжилтын төлөвлөгөөний хэрэгжилтэд тогтмол мониторинг хийх;

62.5.5.хадгаламж, зээлийн хоршоодын төлбөрийн чадварт тогтмол хяналт тавих зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийх, зэрэглэл тогтоох аргачлалыг боловсруулж, мөрдүүлэх;

62.5.6.хадгаламж, зээлийн хоршоодоос жил бүр төвлөрүүлэх тогтворжилтын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох;

62.5.7.тогтворжилтын сан нь эрсдэлийн үнэлгээнд үндэслэн хадгаламж, зээлийн хоршоог сэргээх боломжгүй гэж үзвэл энэ талаарх шийдвэрийг хоршоонд, мөн урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд хийгдсэн ажлын талаар Хороонд мэдэгдэх.

62.6.Төв ХЗХ-ноос үзүүлэх тогтворжилтын үйлчилгээ, тогтворжилтын санд татан төвлөрүүлсэн хөрөнгийг захиран зарцуулах, хяналт тавих харилцааг зохицуулах журмыг Хороо батална.

62.7.Төв ХЗХ тогтворжилтын сангийн үйл ажиллагааны тайланг хагас жил тутам Хороонд хүргүүлнэ.

62.8.Тогтворжилтын сангийн үйл ажиллагаанд Хорооноос хяналт шалгалтыг жилд 1-ээс доошгүй удаа хийнэ.

62.9.Тогтворжилтын сангийн заавал байх нөөцийн хэмжээг Хороо тогтоох ба сангийн хөрөнгө доод хэмжээнд хүрээгүй бол санхүүгийн туслалцаа үзүүлэхийг хориглоно.

62.10.Тогтворжилтын үйлчилгээ авах эрх нь Төв ХЗХ-ноос тогтоосон нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд үүснэ.

62.11.Хадгаламж, зээлийн хоршоо нь тогтворжилтын сангаас санхүүгийн туслалцаа авах хүсэлтийг сэргээх арга хэмжээний төлөвлөгөөний хамт хүргүүлнэ.

63 дугаар зүйл.Төв ХЗХ-ны тогтворжилтын сангийн удирдах зөвлөл

63.1.Төв ХЗХ нь тогтворжилтын санг удирдах зөвлөлтэй байна.

63.2.Тогтворжилтын сангийн удирдах зөвлөл нь Төв ХЗХ-ны гишүүн хадгаламж, зээлийн хоршоодоос ирүүлсэн мөнгөн тусламж хүссэн хүсэлт, сэргээх арга хэмжээний төлөвлөгөөг судлан тогтворжилтын сангаас санхүүгийн болон мэргэжлийн туслалцаа үзүүлэх эсэх асуудлаар шийдвэр гаргана. Мөн гишүүн хоршоодод олгосон туслалцааны мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг хянах ба ажлын тайланг Төв ХЗХ-ны бүх гишүүдийн хуралд тайлагнана.

63.3.Тогтворжилтын сангийн удирдах зөвлөлийн гишүүд болон түүний даргыг төв ХЗХ-ны бүх гишүүдийн хурлаас, гишүүн хадгаламж зээлийн хоршоодоос томилсон төлөөлөгчид дундаас сондгой тоотойгоор гурваас дээшгүй жилийн хугацаагаар томилно.

63.4.Төв ХЗХ-ны удирдах зөвлөл болон хяналтын зөвлөлийн гишүүд нь Тогтворжилтын сангийн удирдах зөвлөлийн гишүүн байж болохгүй. Тогтворжилтын сангийн удирдах зөвлөлийн гишүүн нь өөрийн гүйцэтгэх чиг үүргийг бусдад шилжүүлэх, төлөөлүүлэн гүйцэтгүүлэхгүй.

63.5.Тогтворжилтын сангийн удирдах зөвлөлийн хуралд гишүүдийн тавиас багагүй хувь нь оролцсон тохиолдолд хурал хүчин төгөлдөр болно. Хурлын тогтоолыг хуралд оролцсон гишүүдийн энгийн олонхийн саналаар батална. Удирдах зөвлөлийн гишүүн бүр саналын нэг эрхтэй байна. Саналын тоо тэнцсэн тохиолдолд, удирдах зөвлөлийн даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

63.6.Тогтворжилтын сангийн удирдах зөвлөл нь Төв ХЗХ болон гишүүн хадгаламж зээлийн хоршоодоос өөрийн чиг үүргийг хийж гүйцэтгэхэд шаардлагатай мэдээлэл авах эрхтэй байна.

63.7.Тогтворжилтын сангийн удирдах зөвлөлийн гишүүн бүр олгогдсон эрхийн хүрээнд шийдвэр гаргаж, үүргээ биелүүлээгүй эсхүл эрх мэдлээ хэтрүүлэн ашигласан бол холбогдох хууль, тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ ХАДГАЛАМЖ ХАМГААЛЛЫН ТОГТОЛЦОО

64 дүгээр зүйл.Хадгаламжийн даатгал

64.1.Хадгаламж, зээлийн хоршооны гишүүдийн хадгаламж даатгалтай байна.

64.2.Хадгаламж, зээлийн хоршоодын хадгаламжийн даатгалын үйл ажиллагааг Хадгаламжийн даатгалын корпораци эрхэлнэ.

64.3.Хадгаламж, зээлийн хоршооны хадгаламжийн даатгалтай холбогдсон харилцааг зохицуулах журмыг Хороо батална.

64.4.Хадгаламжийн даатгалын корпораци нь Хорооноос баталсан журмын дагуу сан байгуулж, Үндэсний хорооноос олгосон эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулна.

65 дугаар зүйл.Хадгаламжийн даатгалын хураамж

65.1.Хадгаламж, зээлийн хоршоо хадгаламжийн даатгалын хураамжийг энэхүү хууль болон Хорооноос баталсан журмын дагуу Хадгаламжийн даатгалын корпорацид төлнө.

65.2.Энэ хуулийн 65.1-д заасан хураамж нь дор дурдсан хураамжаас бүрдэнэ:

65.2.1.эхлэлтийн хураамж;

65.2.2.улирлын хураамж;

65.2.3.онцгой хураамж.

65.3.Хороо нь даатгалын хураамжийн хэмжээ, тооцох аргачлалыг журмаар тогтооно.

65.4.Сангийн хөрөнгө нь салбарын нийт даатгагдах хадгаламжийн дүнгийн 10 хувьд хүрсэн тохиолдолд Хадгаламжийн даатгалын корпораци хураамжийг хуримтлуулахыг түр зогсоож болно.

65.5.Хадгаламж, зээлийн хоршооны даатгалын хураамж төлөх үүрэг нь даатгалын тохиолдол бий болсон болсон улирлын эцсийн өдрөөр дуусгавар болно.

65.6.Энэ хуулийн 65.2-д заасан хадгаламж, зээлийн хоршооноос төлсөн хураамжийг буцаан олгохгүй.

66 дугаар зүйл. Даатгалын тохиолдол

66.1.Хорооноос хадгаламж, зээлийн хоршоог санхүүгийн ноцтой хүндрэлд орсон, хадгаламж буцаан төлөх чадваргүй болсон гэж үзэж тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шийдвэр гарсныг даатгалын тохиолдол гэж үзнэ.

66.2.Хадгаламж, зээлийн хоршооны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох Хорооны шийдвэр гарсан, эсхүл хүндрэлд орсон хадгаламж, зээлийн хоршоонд тогтворжилтын үйлчилгээг үзүүлэх боломжгүй гэсэн мэдэгдэл авсан даруйд Хороо энэ талаар хадгаламжийн даатгалын корпорацид мэдэгдэх үүрэг хүлээнэ.

66.3.Даатгалын тохиолдол бий болоход хадгаламж эзэмшигчид нь Хадгаламжийн даатгалын корпорациас хууль, тогтоомжоор тогтоосон нөхөн төлбөр шаардах эрх үүснэ.

67 дугаар зүйл. Даатгагдах хадгаламж болон хадгаламж эзэмшигч

67.1.Дараах хадгаламжийг даатгагдах хадгаламжид тооцохгүй:

67.1.1.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан нэргүй, дугаарласан, эсхүл хуурамч нэрээр нээсэн данс;

67.1.2.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан хийгдэхээр хүлээгдэж байгаа гүйлгээ нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилготой гэж үзэх үндэслэлтэй бол Санхүүгийн мэдээллийн албаны дарга тухайн гүйлгээг ажлын гурав хүртэл өдрийн хугацаагаар гүйлгээг түдгэлзүүлсэн дансны хадгаламж.

68 дугаар зүйл. Хадгаламж, зээлийн хоршооны үүрэг

68.1.Хадгаламж, зээлийн хоршоо нь холбогдох бүртгэлийг хөтөлж, шаардлагатай баримт мэдээллийг гаргаж өгөх, Хадгаламжийн даатгалын корпорацыг хууль, журмаар хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

68.2.Хадгаламж, зээлийн хоршоо энэ хуулийн 68.1-д заасан үүргээ хадгаламжийн даатгалын үйл ажиллагаанд оролцох оролцоо дуусгавар болсноос хойш 3 жилийн хугацаанд биелүүлнэ.

69 дүгээр зүйл. Нөхөн төлбөр олгох

69.1.Хадгаламжийн даатгалын корпораци нь хадгаламж эзэмшигчийн нэхэмжлэл, нотлох баримтад үндэслэн дараах шаардлагыг хангасан тохиолдолд нөхөн төлбөр төлнө:

69.1.1.хадгаламж эзэмшигчийн сангаас нөхөн төлбөр авах нэхэмжлэл нь хууль, журмын дагуу байх;

69.1.2.хадгаламж, зээлийн хоршоо нь хадгаламж эзэмшигчийн нэхэмжлэлийг барагдуулах чадваргүй болсон нь нотлогдсон байх.

69.2.Хадгаламжийн даатгалын корпораци нь хадгаламж эзэмшигчид нөхөн төлбөрийг даатгалын тохиолдол бий болсон өдрөөс хойш 3 сарын дотор олгоно.

69.3.Хамтарсан дансан дахь эзэмшлийн хувь нь тэнцүү биш болохыг нотолсон баримт гаргаснаас бусад тохиолдолд хамтарсан данс эзэмшигчдэд даатгалын нөхөн төлбөрийг тэнцүү хувааж тооцно.

69.4.Хадгаламж эзэмшигч гуравдагч этгээдийн дансыг төлөөлж байгаа тохиолдолд тухайн хадгаламжийг гуравдагч этгээдийнхээр тооцож нөхөн төлбөрийг төлнө.

69.5.Насанд хүрээгүй хамтарсан данс эзэмшигчийн даатгалын нөхөн төлбөр авах эрх тухайн хадгаламжийг бусад этгээдтэй хамтран эзэмшиж байгаагаар хязгаарлагдахгүй.

69.6.Нэхэмжлэлийн дүн нь нотлогдоогүй тохиолдолд бага дүнгээр буюу нотлогдсон хэмжээгээр нөхөн төлбөр олгоно.

69.7.Нөхөн төлбөрийн хэмжээг бүрэн тогтоох хүртэл хохирогчийн хүсэлтийн дагуу нөхөн төлбөрийг хэсэгчлэн олгож болно.

69.8.Дараах тохиолдолд нөхөн төлбөр шаардах эрх үүсэхгүй:

69.8.1.даатгалын тохиолдол бий болсон өдрөөс хойш хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 6 сарын хугацаанд хүсэлт ирүүлээгүй;

69.8.2.хадгаламж эзэмшигч нь тухайн хадгаламж, зээлийн хоршооны дампуурлаас шууд болон шууд бусаар ашиг хүртсэн, эсхүл үйл ажиллагааны болон санхүүгийн хүндрэлд ороход нөлөөлсөн.

70 дугаар зүйл. Даатгагдах хадгаламжийн хэмжээ

70.1.Даатгалын тохиолдол бий болоход Хадгаламжийн даатгалын корпораци хадгаламж эзэмшигчийн нийт 10 сая хүртэл төгрөгийн хадгаламжийг нөхөн төлнө.

71 дүгээр зүйл. Даатгагдах хадгаламжийн тооцоолол

71.1.Даатгагдсан хадгаламжийг тооцохдоо даатгалын тохиолдол бий болсон өдрийн байдлаар хадгаламж эзэмшигч бүрийн тухайн хадгаламж, зээлийн хоршоонд эзэмшиж буй нийт хадгаламжийн дүн болон гэрээний дагуу хуримтлагдсан хүүгийн дүнг нэгтгэж, хадгаламж эзэмшигчээс тухайн хадгаламж зээлийн хоршоонд эргэн төлбөл зохих зээлийн төлбөр, хүүгийн хамт хасаж тодорхойлно.

72 дугаар зүйл. Хадгаламжийн даатгалын сан байгуулах

72.1.Хадгаламжийн даатгалын корпораци нь хадгаламж, зээлийн хоршооны хадгаламжийн даатгалын санг /цаашид “Сан” гэх/-г байгуулж, удирдана.

72.2.Сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

72.2.1.улсын төсвөөс санд оруулсан эхлэлтийн хөрөнгө;

72.2.2.хадгаламж, зээлийн хоршооны төлсөн хадгаламжийн даатгалын хураамж;

72.2.3.хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгө оруулалтаас олсон орлого;

72.2.4.даатгалын тохиолдол бий болсон хадгаламж, зээлийн хоршооны актив хөрөнгийг борлуулснаас олсон орлого;

72.2.5.Засгийн газраас олгосон зээл, тусламж болон бусад санхүүжилт;

72.2.6.банк болон олон улсын санхүүгийн байгууллагаас авсан зээл;

72.2.7.хуульд заасан бусад эх үүсвэр.

73 дугаар зүйл. Нөхөн төлбөрийг хойшлуулах

73.1.Сан шаардлагатай хэмжээнд хүрээгүй тохиолдолд нөхөн төлбөр төлөх хугацааг хойшлуулж болно.

74 дүгээр зүйл. Сангийн хөрөнгийн зарцуулалт

74.1.Дор дурдсанаас бусад тохиолдолд сангаас зарцуулалт хийхийг хориглоно:

74.1.1.хадгаламж эзэмшигчийн нөхөн төлбөрийг олгох;

74.1.2. Үндэсний хорооноос баталсан төсвийн хүрээнд үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх;

74.1.3. санд төвлөрсөн хураамжийг үр ашигтай удирдах, нэмэгдүүлэхтэй холбоотой хөрөнгө оруулалт хийх.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИХ ХЯНАЛТ, ШАЛГАЛТ, АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ

75 дугаар зүйл. Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт, албадлагын арга хэмжээ

75.1. Хадгаламж, зээлийн хоршоо нь энэ хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхэд Хорооноос хяналт тавьж, шалгалт хийнэ.

75.2. Хороо нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааг хянан шалгах эрхтэй.

75.3. Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх, үнэлгээ тогтоох, хуульд заасан албадлагын арга хэмжээ авах журмыг Хороо батална.

75.4. Хадгаламж, зээлийн хоршоо болон түүний холбогдох этгээд хяналт шалгалттай холбоотой өөрсдийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бүртгэл, мэдээ, мэдээлэл болон холбогдох бусад баримт бичгийг Хорооны шаардсанаар гаргаж өгөх үүрэгтэй.

75.5. Санхүү, төлбөрийн чадвар муудсан, өөрийн хөрөнгөгүй болсон тухай бүр хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд Хорооноос хяналт шалгалт хийнэ.

76 дугаар зүйл. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ

76.1. Хадгаламж, зээлийн хоршоо нь энэ хууль, Хорооноос тогтоосон дүрэм, журам, шийдвэрийг зөрчсөн, эсхүл зөрчиж болзошгүй нөхцөл байдал үүссэн, хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаагүй, эсхүл найдваргүй, хэвийн бус үйл ажиллагаа явуулсан бол Хорооноос дараах арга хэмжээг авна:

76.1.1. зөрчил, дутагдлыг арилгах талаар албан шаардлага тавьж, сануулга өгөх;

76.1.2. зөрчил, дутагдлыг арилгах талаар хугацаатай үүрэг, даалгавар өгөх;

76.1.3. үйл ажиллагааг сэргээх төлөвлөгөөг хэрэгжүүлж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг тогтоосон түвшинд хүргэхийг даалгах;

76.1.4. хадгаламж, зээлийн хоршооны өөрийн хөрөнгийг тогтоосон хугацаанд нэмэгдүүлэхийг үүрэг болгох;

76.1.5. хадгаламж, зээлийн хоршооны удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг сайжруулж, бэхжүүлэх арга хэмжээ авахыг даалгах;

76.1.6. тодорхой үйл ажиллагаа явуулах, хэлцэл гүйлгээ хийхэд Хорооноос урьдчилан зөвшөөрөл авахаар тогтоох;

76.1.7. тухайн хадгаламж, зээлийн хоршооны нэг улирлын нийт активын дундаж хэмжээ нь өмнөх улирлын нийт активын дундаж хэмжээнээс хэтрэхгүй байх, эсхүл активыг төрөлжүүлэхийг даалгах;

76.1.8. хөрөнгө худалдан авах, салбар байгуулахыг хориглох;

76.1.9. хадгаламж, зээлийн үйл ажиллагаа явуулахыг хэсэгчлэн болон бүхэлд нь хязгаарлах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх;

76.1.10. хөрөнгө худалдах, салбарыг татан буулгахыг шаардах;

76.1.11. хадгаламж, зээлийн хоршооны гүйцэтгэх удирдлагыг албан тушаалаас түдгэлзүүлэх, чөлөөлөх саналыг тэргүүлэгчдийн зөвлөлд хүргүүлэх;

76.1.12.тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх, дуусгавар болгох, чөлөөлөх саналыг бүх гишүүдийн хуралд хүргүүлэх;

76.1.13.нөхцөлт удирдлагын арга хэмжээ авах;

76.1.14.Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ.

76.2.Хороо энэ зүйлд заасан арга хэмжээ авахдаа тухайн зөрчил, дутагдал, үүссэн нөхцөл байдал, шаардлагад тохирсон арга хэмжээ авах зарчмыг баримтална.

76.3.Энэ зүйлд заасан арга хэмжээг авсан нь энэ хууль, бусад хууль тогтоомжоор Хорооноос арга хэмжээ авах, хариуцлага ногдуулах эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

76.4.Хороо энэ зүйлд заасны дагуу хадгаламж, зээлийн хоршоонд авсан урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар Хадгаламжийн даатгалын корпорацид мэдэгдэнэ.

77 дугаар зүйл. Хадгаламж зээлийн хоршооны үйл ажиллагааг сэргээх арга хэмжээний төлөвлөгөө

77.1.Хадгаламж, зээлийн хоршоо нь өөрийн үйл ажиллагааны онцлог, эдийн засгийн тухайн нөхцөл байдлаас шалтгаалан үүсч болох эрсдэлийг урьдчилан тооцож, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хадгалахад чиглэсэн хариу арга хэмжээг тусгаж, бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлж тэргүүлэгчдийн зөвлөлөөс баталсан үйл ажиллагааг сэргээх төлөвлөгөөг тогтоосон хугацаанд Хороонд ирүүлнэ.

77.2.Хадгаламж, зээлийн хоршооноос ирүүлсэн үйл ажиллагааг сэргээх төлөвлөгөө нь энэ хуулийн 77.1-д заасан шаардлагыг хангаагүй бол Хороо өөрчлөлт оруулахыг хадгаламж, зээлийн хоршооноос шаардана.

77.3.Хадгаламж, зээлийн хоршоо энэ хуулийн 77.2-т заасны дагуу үйл ажиллагааг сэргээх төлөвлөгөөнд зохих өөрчлөлт оруулаагүй буюу уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжгүй гэж Хороо үзвэл дараах шаардлагыг хадгаламж, зээлийн хоршоонд тавина:

77.3.1.хадгаламж, зээлийн хоршооны эрсдэлийн ерөнхий түвшинг бууруулах;

77.3.2.төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг сайжруулах тодорхой арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх;

77.3.3.бизнес төлөвлөгөө, стратегийг өөрчлөх, хадгаламж, зээлийн хоршооны үндсэн үйл ажиллагааг бэхжүүлэх;

77.3.4.хадгаламж, зээлийн хоршооны удирдлага, зохион байгуулалтын бүтцийг өөрчлөх;

77.3.5.Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад шаардлага.

78 дугаар зүйл. Хадгаламж, зээлийн хоршооны нөхцөлт удирдлага

78.1.Хороо нь энэ хуулийн 76 дугаар зүйлд заасан урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааг сайжруулахад хангалтгүй гэж үзсэн, эсхүл хяналт шалгалтаар хадгаламж, зээлийн хоршооны төлбөрийн чадвар муудаж байгаа нь тогтоогдсон бол тухайн хадгаламж, зээлийн хоршооны удирдлага, зохион байгуулалт, санхүү, үйл ажиллагаатай нь холбогдуулан нөхцөлт удирдлагыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, бүрэн эрхт төлөөлөгчийг томилж болно.

78.2.Хороо тухайн хадгаламж, зээлийн хоршоог удирдах бүрэн эрхт төлөөлөгч /цаашид “бүрэн эрхт төлөөлөгч” гэх/-ийг нэг жил хүртэл хугацаагаар томилох бөгөөд бүрэн эрхт төлөөлөгчийн ажиллах журмыг энэ хуульд нийцүүлэн Хороо батална.

78.3.Хадгаламж, зээлийн хоршооны нөхцөлт удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааны зардлыг тухайн хадгаламж, зээлийн хоршоо хариуцна.

79 дугаар зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны нөхцөлт удирдлага хэрэгжүүлэх шийдвэр

79.1.Хадгаламж, зээлийн хоршооны нөхцөлт удирдлага хэрэгжүүлэх тухай Хорооны шийдвэрт дараах зүйлийг тусгана:

79.1.1.хадгаламж, зээлийн хоршооны нэр, оршин байгаа газар, хаяг;

79.1.2.хадгаламж, зээлийн хоршооны нөхцөлт удирдлага хэрэгжүүлэх болсон үндэслэл;

79.1.3.хадгаламж, зээлийн хоршооны нөхцөлт удирдлага хэрэгжүүлж эхлэх болон түүний үргэлжлэх хугацаа;

79.1.4.хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд тавих хязгаарлалтын жагсаалт;

79.1.5.бүрэн эрхт төлөөлөгчийн эцэг /эх/-ийн болон өөрийн нэр.

79.2.Хороо хадгаламж, зээлийн хоршооны нөхцөлт удирдлагын арга хэмжээ авсан тухай шийдвэрийг нийтэд мэдээлж болно.

80 дугаар зүйл.Бүрэн эрхт төлөөлөгч томилох

80.1.Хороо өөрийн ажилтныг, эсхүл бусад этгээдийг хадгаламж, зээлийн хоршооны бүрэн эрхт төлөөлөгчөөр томилж болно.

80.2.Бүрэн эрхт төлөөлөгчийн цалин хөлсийг Хороо тогтоож, тухайн хадгаламж, зээлийн хоршооноос гаргуулна.

80.3.Бүрэн эрхт төлөөлөгч үйл ажиллагаандаа хууль тогтоомж болон энэ хуультай нийцүүлэн гаргасан Хорооны дүрэм, журам, удирдамжийг баримтална.

80.4.Хороо бүрэн эрхт төлөөлөгчийг өөрчлөх эрхтэй.

81 дүгээр зүйл. Хадгаламж, зээлийн хоршооны нөхцөлт удирдлагын үед авах арга хэмжээ, бүрэн эрхт төлөөлөгчийн эрх, үүрэг

81.1.Хороо хадгаламж, зээлийн хоршооны нөхцөлт удирдлага хэрэгжүүлэхдээ дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

81.1.1.тухайн хадгаламж, зээлийн хоршооны удирдлагын эрх, үүргийг бүрэн эрхт төлөөлөгчид түр шилжүүлэх;

81.1.2.хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг хянаж баталгаажуулах, сайжруулах арга хэмжээ авах.

81.2.Бүрэн эрхт төлөөлөгч дараах эрх, үүрэгтэй:

81.2.1.тухайн хадгаламж, зээлийн хоршооны эрхлэх үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар бие даан шийдвэр гаргах;

81.2.2.шаардлагатай гэж үзвэл хадгаламж, зээлийн хоршооны нөхцөлт удирдлага тогтоосон хугацаанд бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөтэй холбогдох үүргийг бүрмөсөн, эсхүл хэсэгчлэн биелүүлэхийг түдгэлзүүлэх;

81.2.3.тухайн хадгаламж, зээлийн хоршооноос урьд нь харилцагчтай хийсэн зээл, хадгаламжийн болон бусад гэрээний нөхцөл нь хадгаламж, зээлийн хоршооны тухайн үеийн ерөнхий нөхцөлөөс өөрөөр тогтоогдож, хадгаламж, зээлийн хоршооны эрх ашигт сөргөөр нөлөөлсөн гэж үзвэл уг гэрээнд өөрчлөлт оруулах, цуцлах, дуусгавар болгох;

81.2.4.хадгаламж, зээлийн хоршооны нэрийн өмнөөс гэрээ байгуулах;

81.2.5.хадгаламж, зээлийн хоршооны нэрийн өмнөөс нэхэмжлэл гаргах;

81.2.6.хадгаламж, зээлийн хоршооноос ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг цуцлах, түүнд өөрчлөлт оруулах, шаардлагатай ажилтныг түр хугацаагаар авч ажиллуулах;

81.2.7.хадгаламж, зээлийн хоршооны өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хангах зорилгоор түүний бүтэц, хэмжээг өөрчлөх.

81.3.Нөхцөлт удирдлага хэрэгжүүлсэн хадгаламж, зээлийн хоршооны гүйцэтгэх удирдлага ажлын тайлан, орлогын мэдүүлгээ зохих журмын дагуу бүрэн эрхт төлөөлөгчид гаргаж өгнө.

81.4.Бүрэн эрхт төлөөлөгчийн албан ёсны зөвшөөрөлгүйгээр тухайн хадгаламж, зээлийн хоршооны нэрийн өмнөөс болон тухайн хадгаламж, зээлийн хоршооны зардлаар хийсэн ажил, гүйлгээг хүчингүйд тооцно.

81.5.Хадгаламж, зээлийн хоршооны хэвийн үйл ажиллагаа хангагдсан нөхцөлд Хороо нөхцөлт удирдлагыг цуцалж, тухайн хадгаламж, зээлийн хоршоонд тогтоосон хязгаарлалтыг бүр мөсөн, эсхүл хэсэгчлэн хүчингүй болгоно.

81.6.Бүрэн эрхт төлөөлөгч өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас учруулсан хохирлыг хариуцах бөгөөд хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны ердийн эрсдэлд хамруулж болох хохирол учирсан нь бүрэн эрхт төлөөлөгчид хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй.

81.7.Бүрэн эрхт төлөөлөгчийн шийдвэрийг тухайн хадгаламж, зээлийн хоршоо, түүний салбар биелүүлэх үүрэгтэй бөгөөд уг шийдвэрийг дагаж мөрдсөнөөс үүсэх хариуцлагыг Хороо хүлээнэ.

82 дугаар зүйл.Өөрчлөн байгуулах арга хэмжээ авах эрх, зарчим

82.1.Бүрэн эрхт төлөөлөгч томилогдон ажилласан хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааг дараах үндэслэлээр цаашид үргэлжлүүлэн эрхлэх боломжгүй бол Хороо энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу хадгаламж, зээлийн хоршоог өөрчлөн байгуулах шийдвэр гаргах эрхтэй:

82.1.1.хадгаламж, зээлийн хоршоо төлбөрийн чадваргүй болсон, эсхүл төлбөрийн чадваргүй болох гарцаагүй нөхцөл байдал үүссэн;

82.1.2.хадгаламж, зээлийн хоршооны хэвийн үйл ажиллагааг цаашид хангах боломжгүй болсон тухай Хорооны хяналт шалгалтын дүгнэлт гарсан;

82.1.3.өөрчлөн байгуулах арга хэмжээ авах нь нийтийн ашиг сонирхлыг хангахад зайлшгүй шаардлагатай.

82.2.Хороо доор дурдсан нөхцөл байдлын аль нэг нь бүрдсэн тохиолдолд энэ хуулийн 82.1.1-д заасан үндэслэл бий болсонд тооцно:

82.2.1.хадгаламж, зээлийн хоршоо хадгаламж эзэмшигч, гишүүн харилцагч, бусад үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий этгээдийн мөнгийг тэдний анхны шаардлагаар гарган өгч чадахгүй болсон эсхүл гаргаж өгөх боломжгүй нь хяналт шалгалтаар тогтоогдсон;

82.2.2.зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүйгээс цаашид үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон;

82.2.3.хадгаламж, зээлийн хоршооны пассив нь активаасаа хэтэрсэн, эсхүл ердийн боломжит хугацаанд хэтрэх нь хяналт шалгалтаар тогтоогдсон.

82.3.Хороо хадгаламж, зээлийн хоршоог өөрчлөн байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ санхүүгийн тогтвортой байдлыг хангах, шуурхай, үр нөлөөтэй байх, төрөөс гарах зардлыг багасгах, хадгаламж эзэмшигч, гишүүн харилцагчийн эрх ашгийг хамгаалах зарчмыг баримтална.

82.4.Энэ хуулийн 82.1-д заасан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Хороо хадгаламж, зээлийн хоршоог албадан татан буулгах шийдвэр гаргана.

82.5.Хороо энэ зүйлд заасан арга хэмжээг авсан тухай шийдвэрээ Хадгаламжийн даатгалын корпорацид мэдэгдэнэ.

82.6.Хадгаламж, зээлийн хоршоог өөрчлөн байгуулах арга хэмжээ авахад бүх гишүүдийн хурлыг хуралдуулахгүй бөгөөд хадгаламж, зээлийн хоршооны үүргийн гүйцэтгэл шаардах эрх бүхий этгээдийн зөвшөөрлийг авах шаардлагагүй.

82.7.Хороо энэ хуульд нийцүүлэн хадгаламж, зээлийн хоршоог өөрчлөн байгуулах арга хэмжээ авах, хэрэгжүүлэх журмыг батална.

83 дугаар зүйл.Хадгаламж, зээлийн хоршоог өөрчлөн байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэх

83.1.Хадгаламж, зээлийн хоршоог өөрчлөн байгуулах арга хэмжээг Хорооноос томилсон тусгай төлөөлөгч хэрэгжүүлнэ.

83.2.Тусгай төлөөлөгч нь дараах шаардлагыг хангасан байна:

83.2.1.хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны мэдлэг, туршлага, мэргэжлийн ёс зүй, мэргэшлийн ур чадвартай;

83.2.2.гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлж байгаагүй;

83.2.3.тухайн хадгаламж, зээлийн хоршооны гишүүн бус, урьд нь авсан хугацаа хэтэрсэн зээлийн өргүй;

83.2.4.тухайн хадгаламж, зээлийн хоршооны тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн дарга, гишүүн, зээлийн хорооны дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, бусад ажилтантай холбогдох этгээдийн харилцаагүй;

83.2.5.хуулийн этгээд бол өөрийн үйл ажиллагааг хариуцах хангалттай хэмжээний хөрөнгө, санхүүгийн эх үүсвэртэй.

83.3.Тусгай төлөөлөгчийн цалин хөлсийг Хороо тогтооно.

83.4.Тусгай төлөөлөгч Хорооны шийдвэрийг дагаж мөрдөнө.

83.5.Тусгай төлөөлөгч томилогдсоноор хадгаламж, зээлийн хоршоо, түүний удирдлага, эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх болон хадгаламж, зээлийн хоршооны хөрөнгийг захиран зарцуулах эрх нь Тусгай төлөөлөгчид шилжинэ.

83.6.Хадгаламж, зээлийн хоршоог өөрчлөн байгуулах арга хэмжээ 90 хоногийн хугацаатай байна. Энэ хугацааг мөн хугацаагаар хоёр удаа сунгаж болно.

83.7.Тусгай төлөөлөгч нь хадгаламж, зээлийн хоршооны актив, пассивын үнэлгээг хараат бус, хөндлөнгийн, мэргэжлийн этгээдээр зохих стандарт, шаардлагын дагуу хийлгэнэ.

83.8.Тусгай төлөөлөгч нь энэ хуульд заасан хадгаламж, зээлийн хоршоог өөрчлөн байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэхээс гадна дараах бүрэн эрхтэй байна:

83.8.1.хадгаламж, зээлийн хоршооны өр төлбөрийн эргэн төлөгдөх хугацаанд өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх;

83.8.2.хадгаламж, зээлийн хоршооны байгуулсан санхүүгийн гэрээ, хэлцлийг дуусгавар болгох;

83.8.3.хадгаламж, зээлийн хоршоонд хөрөнгө оруулахыг тухайн хадгаламж, зээлийн хоршооны гишүүдээс шаардах;

83.9.Тусгай төлөөлөгч нь Хороонд ажлаа хариуцан тайлагнана.

83.10.Тусгай төлөөлөгчийн цалин хөлс, холбогдох бусад зардлыг тухайн хадгаламж, зээлийн хоршооноос гаргуулна.

84 дүгээр зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны актив, пассивыг шилжүүлэх

84.1.Тусгай төлөөлөгч хадгаламж, зээлийн хоршооны актив, пассивыг эрх бүхий хадгаламж, зээлийн хоршоонд шилжүүлж болно.

84.2.Энэ хуулийн 84.1-т заасан шилжүүлэг хийхдээ энэ хуульд заасны дагуу хийсэн үнэлгээг баримтална.

84.3.Хадгаламж, зээлийн хоршооны шилжүүлгийг хийхэд шаардагдах санхүүжилтийн нөхцөл, хэлбэр, хэмжээг тусгай төлөөлөгчийн саналыг харгалзан Хороо тодорхойлно.

84.4.Хадгаламж, зээлийн хоршоог шилжүүлэх шийдвэр нь тухайн хадгаламж, зээлийн хоршооны актив, пассив, тэнцлийн гадуурх зүйлтэй холбоотойгоор өмнө байгуулсан гэрээ, хэлцэл, шийдвэрийн зохицуулалтаас үл хамааран хэрэгжинэ.

84.5.Хадгаламж, зээлийн хоршоог шилжүүлсэн нь хадгаламж, зээлийн хоршооноос урьд нь бусадтай байгуулсан гэрээ, хэлцлийг хугацаанаас өмнө татгалзах, цуцлах үндэслэл болохгүй.

84.6.Энэ хуулийн 84.1-т заасан арга хэмжээг авахад өр төлбөрт барьцаалагдсан эд хөрөнгийг тухайн өр төлбөр, уг үүргийн гүйцэтгэлийг хангуулах бусад дагалдах эрхийн хамт шилжүүлнэ.

84.7.Энэ зүйлд заасан арга хэмжээний хүрээнд буцаан төлөгдсөн хөрөнгийн хэмжээ нь тухайн хадгаламж, зээлийн хоршоог шууд татан буулгасны үр дүнд буцаан төлөгдөх боломжтой байсан хөрөнгийн хэмжээнээс багассан болох нь тогтоогдсон тохиолдолд тухайн

хадгаламж, зээлийн хоршооноос төлбөр гаргуулах шаардлага нь бусдад шилжээгүй үүрэг гүйцэтгүүлэгч уг зөрүүгээр нөхөн төлбөр гаргуулахыг шаардах эрхтэй.

85 дугаар зүйл. Өөрчлөн байгуулах арга хэмжээг дуусгавар болгох

85.1. Өөрчлөн байгуулах арга хэмжээг Хороо дараах үндэслэлээр дуусгавар болгоно:

85.1.1. хадгаламж, зээлийн хоршоог өөрчлөн байгуулах арга хэмжээ авах үндэслэл арилсан;

85.1.2. өөрчлөн байгуулах арга хэмжээний хэрэгслийг ашиглах шаардлагагүй болсон.

85.2. Өөрчлөн байгуулах арга хэмжээ авагдаж байгаа хадгаламж, зээлийн хоршоо нь Хорооноос гаргасан журамд нийцэхүйц хангалттай хэмжээгээр дахин хөрөнгөжсөнөөс бусад тохиолдолд өөрчлөн байгуулах арга хэмжээ дуусгавар болсон бол хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хороо хүчингүй болгоно.

85.3. Энэ хуулийн 85.1-д заасны дагуу өөрчлөн байгуулах арга хэмжээний үр дүнд энэ хуульд заасан хадгаламж, зээлийн хоршоонд тавигдах шаардлагыг хадгаламж, зээлийн хоршоо хангаж дахин хөрөнгөжсөн бол удирдлагын бүрэн эрхийг шилжүүлэх шийдвэрийг Хороо гаргана.

85.4. Энэ хуулийн 85.2-т заасан шийдвэрт өөрчлөн байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэгч этгээдийн бэлтгэсэн өөрчлөн байгуулахад гарсан зардлыг тусгасан тайланг хавсаргасан байна.

АРАВДУГААР БҮЛЭГ ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

86 дугаар зүйл. Хадгаламж, зээлийн хоршоог бүх гишүүдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулах, татан буулгах үндсэн нөхцөл

86.1. Хадгаламж, зээлийн хоршоог өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй харилцааг Иргэний хууль болон холбогдох бусад хуулиар зохицуулна.

86.2. Хорооны зөвшөөрлийг үндэслэн Хадгаламж, зээлийн хоршоог өөрчлөн байгуулах шийдвэрийг бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэх бөгөөд хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.

86.3. Хадгаламж, зээлийн хоршоог нийлүүлэх, нэгтгэх замаар өөрчлөн байгуулж болно.

86.4. Хадгаламж, зээлийн хоршоог шүүхийн шийдвэрээр эсхүл, Хорооноос бичгээр зөвшөөрсөн тохиолдолд бүх гишүүдийн хурлын шийдвэрээр татан буулгана.

86.5. Хадгаламж, зээлийн хоршоог өөрчлөн байгуулах, татан буулгах зөвшөөрөл авахад Хороонд дор дурдсан баримт бичгийг ирүүлнэ:

86.5.1. өргөдөл;

86.5.2. өөрчлөн байгуулах, татан буулгах тухай бүх гишүүдийн хурлын шийдвэр;

86.5.3. өөрчлөн байгуулах, татан буулгах шаардлага, өөрчлөн байгуулагдах, төлөвлөгөө, үе шат, татан буулгасны дараа гишүүдэд ногдох хөрөнгийн тооцоо зэргийг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж гаргасан шийдвэр, санхүүгийн тайлан болон шаардлагатай бусад мэдээлэл;

86.5.4. өөрчлөн байгуулагдсанаас үүсэх санхүүгийн үр дүнгийн тооцоо, өөрчлөн байгуулагдсаны дараах хуулийн этгээдийн эхлэлтийн тайлан тэнцэл.

86.6. хадгаламж, зээлийн хоршоог өөрчлөн байгуулах, татан буулгах тухай шийдвэрт өөрчлөн байгуулах, татан буулгах комисс, тэдгээрийн бүрэлдэхүүнийг томилох тухай тусгасан байна.

86.7. Хороо нь холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор тухайн хадгаламж, зээлийн хоршоог өөрчлөн байгуулах, татан буулгах зөвшөөрөл олгох эсэх

асуудлыг хянан шийдвэрлэж, шийдвэрийг тухайн хадгаламж, зээлийн хоршоонд хүргүүлж, олон нийтэд мэдээлнэ.

86.8.Хадгаламж, зээлийн хоршоог өөрчлөн байгуулах, татан буулгах тухай бүх гишүүдийн хурлын шийдвэр нь хууль тогтоомж зөрчсөн, эсхүл тухайн хадгаламж, зээлийн хоршооны гишүүд, авлагатай иргэн, хуулийн этгээдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр бол Хороо зөвшөөрөл өгөхөөс татгалзаж болно.

86.9.Хороо шаардлагатай гэж үзвэл хадгаламж, зээлийн хоршоог өөрчлөн байгуулах ажиллагааны явцад газар дээрх хяналтыг хэрэгжүүлж, арга зүйн зөвлөгөө өгч болно.

86.10.Хороо өөрчлөн байгуулах, татан буулгах зөвшөөрөл олгохоос татгалзсан бол бүх гишүүдийн хурлын шийдвэрийг хүчингүй болсонд тооцно.

86.11.Шүүх хадгаламж, зээлийн хоршоог дор дурдсан үндэслэлээр татан буулгана:

86.11.1.хуульд заасан хугацаанд тусгай зөвшөөрөл хүсэж Хороонд хандаагүй;

86.11.2.тусгай зөвшөөрөл олгосноос хойш нэг жилийн хугацаанд тусгай зөвшөөрлөөр олгогдсон үйл ажиллагааг эрхлээгүй;

86.11.3.тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон;

86.11.4.хуульд заасан бусад үндэслэл.

86.12.Хороо энэ хуулийн 86.11-т заасан үндэслэлээр хадгаламж, зээлийн хоршоог татан буулгах шийдвэр гаргуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргаж болно.

87 дугаар зүйл. Хадгаламж, зээлийн хоршоо сайн дураар татан буугдах

87.1.Хадгаламж, зээлийн хоршоо нь цаашид үйл ажиллагаагаа явуулах хугацаа дууссан эсхүл зорилгодоо хүрсэн учир цаашид үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх шаардлагагүй гэсэн шийдвэрийг бүх гишүүдийн хурлаас гаргасан бол өөрийн хүсэлтээр татан буугдаж болно.

87.2.Өөрийн хүсэлтээр татан буугдаж байгаа хоршооны Тэргүүлэгчдийн зөвлөл нь татан буулгах комисс томилох, татан буулгах хугацаа, журам, харилцагч, гишүүдийн нэхэмжлэлийг барагдуулсаны дараа хоршоонд үлдэх эд хөрөнгийг гишүүдэд хуваарилах журам зэргийг тусгасан татан буулгах төлөвлөгөөний төслийг бүх гишүүдийн хуралд танилцуулж, оролцогч гишүүдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.

87.3.Хадгаламж, зээлийн хоршоо нь өөрийн хүсэлтээр татан буугдах бол татан буулгах үед өр төлбөрийг барагдуулахдаа Иргэний хууль, энэ хууль болон бусад хуулийг дагаж мөрдөх ба дараах баримт бичгийг Хороонд ирүүлнэ. Үүнд:

87.3.1.Хороонд татан буугдах болсон шалтгааны талаар дурдсан албан бичгээр ирүүлсэн хүсэлт;

87.3.2.хадгаламж, зээлийн хоршооны бүх гишүүдийн хурлын ирцийн мэдээ, саналын хэмжээ, тэмдэглэл, хурлын шийдвэр;

87.3.3.хадгаламж, зээлийн хоршоог татан буулгах комисс томилсон ажлын хэсгийн шийдвэр;

87.3.4.хадгаламж, зээлийн хоршоо нь мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгийн дансны хуулга, түргэн борлогдох активтай холбоотой баримт бичгүүд, хадгаламж эзэмшигчдийн бүртгэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн жагсаалт, зээлдэгчдийн бүртгэл, бусад өр төлбөрийн бүртгэлтэй холбоотой баримт бичгүүд, орлогыг хуваарилах, өр төлбөрийг барагдуулах төлөвлөгөө, түүнтэй холбоотой баримт бичгүүд;

87.3.5.хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан;

87.3.6.тусгай зөвшөөрлийн гэрчилгээг хавсралтын хамт;

87.3.7.Хорооноос шаардлагатай гэж үзсэн холбогдох бусад баримт бичиг.

87.4.Хадгаламж, зээлийн хоршооны хүсэлтийг Хороо хянан үзээд татан буулгахад гишүүдийн эрх ашиг, мөнгөн хөрөнгө болон бусад хөрөнгөд сөргөөр нөлөөлөхгүй гэж үзсэн тохиолдолд татан буулгах шийдвэрийг гаргана.

87.5.Хадгаламж, зээлийн хоршоо нь Хороо татан буулгах шийдвэрийг гаргасан өдрөөс хойш татан буулгах комиссыг ажлуулах ба татан буулгах комисс нь харьяа татварын

байгууллагад мэдэгдэж хуулийн этгээдийн бүртгэлийг улсын бүртгэлээс хасуулах ажлыг хийж гүйцэтгэнэ.

88 дугаар зүйл. Татан буулгах комисс томилох

88.1. Хороо нь энэ хуульд заасан албадлагын арга хэмжээний хүрээнд хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд тухайн хадгаламж, зээлийн хоршоог албадан татан буулгах шийдвэр гаргаж, татан буулгах комисс томилж болно.

88.2. Татан буулгах комисс нь хадгаламж, зээлийн хоршоо, түүний эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх болон хадгаламж, зээлийн хоршооны хөрөнгийг захиран зарцуулах эрхтэй байх бөгөөд хадгаламж, зээлийн хоршооны активыг төлүүлэх, өр төлбөрийг барагдуулж, нэхэмжлэгчдийн шаардлагыг хангах, орлогыг хуваарилах чиг үүрэгтэй байна.

88.3. Хороо нь шаардлага хангасан өөрийн ажилтан, эсхүл бусад этгээдийг татан буулгах комиссын гишүүдээр томилно.

88.4. Татан буулгах комиссын гишүүдийн цалин хөлсийг Хороо тогтоож, хадгаламж, зээлийн хоршоог татан буулгах үйл ажиллагааны зардлыг тухайн хадгаламж, зээлийн хоршооноос гаргуулна.

88.5. Татан буулгах комисс нь хадгаламж, зээлийн хоршоог татан буулгах хугацаа, хадгаламж, зээлийн хоршоо хадгаламжийн үйл ажиллагаа явуулахгүй тухай болон шаардлагатай гэж үзсэн бусад асуудлыг тусгасан татан буулгах тухай шийдвэрийг олон нийтэд мэдээлнэ.

88.6. Татан буулгах комисс нь дараах үүргийг хэрэгжүүлнэ:

88.6.1. эд хөрөнгийг захиран зарцуулах;

88.6.2. хадгаламж, зээлийн хоршоог төлөөлөх, удирдах;

88.6.3. хадгаламж, зээлийн хоршооны гэрээ байгуулах, цуцлах;

88.6.4. хадгаламж, зээлийн хоршооны өр төлбөрийг хязгаарлах, шилжүүлэх, зогсоох;

88.6.5. хадгаламж, зээлийн хоршооны нэрийн өмнөөс Хорооноос тогтоосон хэмжээг баримтлан төлбөр хийх.

88.6.6. хадгаламж, зээлийн хоршооноос байгуулсан хөдөлмөрийн болон бусад гэрээг цуцлах;

88.6.7. хадгаламжийн хүүгийн хувь хэмжээг тухайн үеийн хадгаламжийн хүүгийн доод хувь хэмжээнээс багагүй байхаар өөрчлөн тогтоох;

88.6.8. хадгаламж, зээлийн хоршооны хөрөнгө оруулалт хийхээр байгуулсан гэрээг цуцлах, зээлийн хүү, үйлчилгээний хөлсний хувь хэмжээ, хугацаанд өөрчлөлт оруулах;

88.6.9. хадгаламж, зээлийн хоршооны хадгаламж эзэмшигч, харилцагчид өгөх төлбөрөөс тухайн хадгаламж эзэмшигч, харилцагчдаас авах зээлийн төлбөрийг суутгах;

88.6.10. татан буулгах арга хэмжээний хүрээнд тухайн хадгаламж, зээлийн хоршоотой холбогдох зарим үйл ажиллагааг үргэлжлүүлэх, зогсоох;

88.6.11. шаардлагатай ажилтан авах, чөлөөлөх;

88.6.12. хадгаламж, зээлийн хоршооны хөрөнгийн тооллогыг хийж, хадгалах;

88.6.13. өр төлбөрийг барагдуулах;

88.6.14. хадгаламж, зээлийн хоршооны хөрөнгийг гишүүдэд хуваарилах;

88.6.15. хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааг дуусгавар болгох.

88.7. Татан буулгах ажиллагааны явцад зээлдэгч гишүүдийн зээл, зээлийн эргэн төлөлттэй холбоотой мэдээллийг Монголбанкны зээлийн мэдээллийн санд хүргүүлж, татан буулгах ажиллагааг дуусгавар болсон гэж үзвэл зээлийн мэдээллийн сантай байгуулсан гэрээг цуцлах хүсэлтийг хүргүүлнэ.

88.8. Гишүүн, эрх бүхий албан тушаалтан, бусад ажилтан, хөндлөнгийн аудиторын үйл ажиллагаанд эдийн засгийн гэмт хэргийн шинжтэй нөхцөл байдал илэрсэн бол татан буулгах комисс Хороонд нэн даруй мэдэгдэж, тухайн асуудлыг шалгуулж, шийдвэрлүүлэхээр хууль хяналтын холбогдох байгууллагад хандана.

88.9.Татан буулгах комисс хадгаламж, зээлийн хоршоог татан буулгах ажиллагаатай холбоотой бүхий л мэдээллийг Хороонд хүргүүлж, тогтоосон хугацаанд тайланг тогтмол ирүүлнэ.

88.10.Татан буулгах комисс хадгаламж, зээлийн хоршооны хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авах үүрэгтэй.

88.11.Хорооноос татан буулгах үйл ажиллагааг холбогдох журмын дагуу явуулсан гэж үзвэл энэ тухай шийдвэрийг холбогдох шүүхэд хүргүүлж, олон нийтэд мэдээлж, тухайн хадгаламж зээлийн хоршоог хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасуулах хүсэлтийг эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

88.12.Хадгаламж, зээлийн хоршооноос хийгдсэн төлбөр, шилжүүлэг зарим этгээдийн эрх ашгийг бусдаас илүүд авч үзсэн байх шинжтэй бол татан буулгах үйл ажиллагаа эхлэхээс өмнөх гурван сарын дотор хийгдсэн төлбөрийг, хэрэв төлбөр хүлээн авагч нь тухайн хадгаламж, зээлийн хоршооны гишүүн, тэргүүлэгчдийн болон хяналтын зөвлөлийн, зээлийн хорооны дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага, ажилтан, тэдгээрт холбогдох этгээд байвал хадгаламж, зээлийн хоршоог татан буулгах үйл ажиллагаа эхлэхээс өмнөх 12 сарын дотор хийгдсэн бүх төлбөрийг доор дурдсанаас бусад тохиолдолд хүчингүйд тооцно:

88.12.1.аливаа хадгаламж эзэмшигчид төлсөн төлбөр нь тухайн үед Хорооноос тогтоосон нэг хадгаламж эзэмшигчид төлөх хязгаараас хэтрээгүй;

88.12.2.бусдад шилжүүлсэн хөрөнгө нь тухайн үеийн зах зээлийн үнээр төлөгдсөн;

88.12.3.хадгаламж, зээлийн хоршооны гүйцэтгэх удирдлага, ажилтанд олгосон цалин хөлс нь тэдгээрт урьд олгож байсан цалин хөлсний ердийн хэмжээнээс хэтрээгүй ба шагнал, бусад тусгай нэмэгдэл үүнд хамаарахгүй.

89 дүгээр зүйл.Хадгаламж, зээлийн хоршоог татан буулгах арга хэмжээ хэрэгжих нөхцөл

89.1.Хадгаламж, зээлийн хоршоог татан буулгах комисс томилогдсон бол хадгаламж, зээлийн хоршоог албадан татан буулгах арга хэмжээ дараах нөхцөлийн дагуу хэрэгжинэ:

89.1.1.хадгаламж, зээлийн хоршоог албадан татан буулгах шийдвэр гарснаас хойш хугацаанд хадгаламж, зээлийн хоршооны гүйцэтгээгүй мөнгөн төлбөрийн үүрэгт хүү, алданги, торгууль тооцохгүй;

89.1.2.хадгаламж, зээлийн хоршоонд холбогдох иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 80.1.1-д заасны дагуу түдгэлзүүлнэ;

89.1.3.татан буулгах комиссоос бусад этгээд хадгаламж, зээлийн хоршооны хөрөнгөөс үл маргах журмаар аливаа шаардлагыг хангуулах эрхгүй;

89.1.4.хадгаламж, зээлийн хоршооны татан буулгах үйл ажиллагаа хэрэгжих хугацаанд урьд гарсан шүүхийн шийдвэрийн дагуу тухайн хадгаламж, зээлийн хоршооны зээлийн барьцаалсан эд хөрөнгө болон актив хөрөнгийг борлуулснаас орох орлогоос үл маргах журмаар төлбөр гүйцэтгэхийг хориглоно.

89.2.Хадгаламж, зээлийн хоршоог албадан татан буулгахад хүндрэл учруулж болзошгүй, зарим этгээдийн эрх ашгийг бусдаас илүүтэйд үзсэн шинжтэй, эсхүл хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааг зохицуулахад болон гишүүн харилцагч, хадгаламж эзэмшигчийн эрх ашгийг хамгаалахад сөрөг нөлөөтэй, хадгаламж, зээлийн хоршооны гүйцэтгээгүй үүргээс татан буулгах комисс татгалзах эрхтэй.

90 дүгээр зүйл.Мэдэгдэл болон нэхэмжлэл хүргүүлэх

90.1.Татан буулгах комисс нь хадгаламж, зээлийн хоршооноос үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий этгээдийн нэхэмжлэлийг хүлээн авах хугацааг мэдэгдэл гаргаснаас хойш 60 хоног байхаар тогтоож, томилогдсон өдрөөс хойш хоёр сарын дотор хадгаламж, зээлийн хоршооны санхүүгийн тайлан, данс мэдээлэлд бүртгэгдсэн үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий этгээдэд мэдэгдэж олон нийтэд мэдээлнэ.

90.2.Татан буулгах комисс нь хадгаламж эзэмшигч болон зээлдэгч гишүүдэд нэхэмжлэлээ бүрэн нотлох боломжийг олгож, бүрдүүлэх баримт бичгийг ирүүлэх талаар мэдэгдэл хүргүүлнэ.

90.3.Энэ хуулийн 90.1-д заасан нэхэмжлэл хүлээн авах эцсийн хугацаа өнгөрснөөс хойш 90 хоногийн дотор татан буулгах комисс дараах шийдвэрийг гаргана:

90.3.1.нэхэмжлэлийн шаардлага хүчин төгөлдөр эсэхэд үндэслэл бүхий эргэлзээ байвал шаардлагыг хүлээн авахаас татгалзах;

90.3.2.хадгаламж, зээлийн хоршооноос үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх бүхий этгээдийн шаардлагын хэмжээг тодорхойлж, энэ хуульд заасны дагуу нэхэмжлэлийн дарааллыг тогтоох;

90.3.3.хадгаламж, зээлийн хоршоог албадан татан буулгах үүднээс татан буулгах комиссын гишүүдийн цалин хөлс, зээлдүүлэгчийн нэрс, баталгаажсан нэхэмжлэл бүрийн үнийн дүн болон төлөх төлбөрийн нийт дүнг тусгасан татан буулгах арга хэмжээний төлөвлөгөө батлах;

90.3.4.нэхэмжлэлийн шаардлага болон түүний баталгаажсан хэмжээний талаар нэхэмжлэгч этгээдэд мэдэгдэх.

90.4.Нэхэмжлэл ирүүлэх мэдэгдэл гарсан өдрөөс хойш 6 сарын дотор татан буулгах комисст хүргүүлээгүй нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах эрхтэй.

91 дүгээр зүйл.Хүчин төгөлдөр бус гэж тооцож болох хэлцэл

91.1.Татан буулгах комисс томилогдсоноос хойш нэг жилийн хугацаанд багтаан дараах хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар эрх бүхий байгууллагад хандаж болно:

91.1.1.татан буулгах комисс томилогдохоос өмнөх нэг жилийн хугацаанд хадгаламж, зээлийн хоршоонд илт хохиролтой байгуулсан хэлцэл;

91.1.2.татан буулгах комисс томилогдохоос өмнөх зургаан сарын дотор хадгаламж, зээлийн хоршооноос авлагатай этгээдийн шаардлагыг хангасан аливаа хэлцэл нь тухайн этгээдийн хувьд татан буулгах ажиллагаанаас олж авах байсан хөрөнгийг ихэсгэсэн хэлцэл;

91.1.3.татан буулгах комисс томилогдохоос өмнөх нэг жилийн хугацаанд хадгаламж, зээлийн хоршоос холбогдох этгээдтэй хийсэн, хадгаламж, зээлийн хоршооны төлбөрийн чадвар алдагдахад нөлөөлсөн хэлцэл.

92 дугаар зүйл.Нэхэмжлэлийн шаардлага хангах дараалал

92.1.Татан буугдаж байгаа хадгаламж, зээлийн хоршоонд холбогдох шаардлагыг дараах дарааллаар хангана:

92.1.1.бусдын амь нас, эрүүл мэндэд учруулсан гэм хорыг арилгуулах тухай шүүхийн шийдвэрийг үндэслэн тухайн хадгаламж, зээлийн хоршооноос гаргуулах төлбөр;

92.1.2.татан буулгах комиссын үйл ажиллагааны зардал;

92.1.3.хадгаламжийн даатгалын сангийн хөрөнгө;

92.1.4.даатгагдаагүй хадгаламжийн төлбөр;

92.1.5.зээлдүүлэгчид өгөх баталгаажсан зээл, өр төлбөр;

92.1.6.хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсад төлөх хөдөлмөрийн хөлс, бусад өр төлбөр болон цалин;

92.1.7.Хорооны шаардах эрх бүхий төлбөр;

92.1.8.Засгийн газарт төлөх өр төлбөр, албан татвар;

92.1.9.гишүүдийн оруулсан хувь хөрөнгө;

92.1.10.үүргийн гүйцэтгэлийг хангах аргаар баталгаажуулаагүй бусад өр төлбөр.

92.2.Татан буугдаж байгаа хадгаламж, зээлийн хоршоонд холбогдох нэхэмжлэлийн шаардлагыг хангахдаа эхний дарааллын төлбөрийг бүрэн барагдуулсны дараа түүний дараагийн дарааллын төлбөрийн шаардлагыг хангах зарчмыг баримтална.

92.3.Хадгаламж, зээлийн хоршоонд байгаа хөрөнгө нь нэхэмжлэлийн шаардлагыг хангахад хүрэлцэхгүй бол татан буулгах комисс бусад эд хөрөнгийг хуульд заасан журмын дагуу худалдаж, төлбөрийг барагдуулж болно.

92.4.Татан буугдаж байгаа хадгаламж, зээлийн хоршооны эд хөрөнгө төлбөр төлөхөд хүрэлцэхгүй бол түүний эд хөрөнгийг төлбөл зохих төлбөрийн хэмжээнд хувь тэнцүүлэн зохих дарааллын дагуу харилцагчдад хуваарилна.

92.5.Гишүүдийн шаардлагыг хангасны дараа үлдсэн эд хөрөнгийг хууль ёсны өмчлөгчид, хууль буюу дүрэмд заасан бол эрх бүхий этгээдэд шилжүүлэх ба татан буугдаж байгаа хадгаламж, зээлийн хоршооны эд хөрөнгийг хүлээж авах этгээд байхгүй бол Төв ХЗХ-ны нөөцийн санд шилжүүлнэ.

93 дугаар зүйл.Татан буулгах үйл ажиллагааг дуусгавар болгох, тайлагнах

93.1.Хадгаламж, зээлийн хоршооны бүх хөрөнгийг худалдан борлуулсан, хуваарилсан, шилжүүлсний дараа хадгаламж, зээлийн хоршооны татан буулгах комисс нь хадгаламж, зээлийн хоршоог татан буулгах ажиллагааны тайланг Хороонд хүргүүлнэ.

93.2.Хороо татан буулгах комиссын тайланг хэлэлцэн баталж, хадгаламж, зээлийн хоршооны татан буулгах арга хэмжээг дуусгавар болгосон бол энэ тухай шийдвэрийг холбогдох шүүхэд хүргүүлж, олон нийтэд мэдээлж хадгаламж, зээлийн хоршоог хуулийн этгээдийн улсын бүртгэлээс хасуулах хүсэлтийг эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.

93.3.Энэ хуулийн 92.2-т заасны дагуу олон нийтэд мэдээлснээр хадгаламж, зээлийн хоршооны татан буулгах комиссын хадгаламж, зээлийн хоршоог татан буулгах үйл ажиллагаатай холбоотой үүрэг дуусгавар болно.

94 дүгээр зүйл.Эрх зүйн хамгаалалт

94.1.Хадгаламж, зээлийн хоршоонд албадлагын арга хэмжээ авах тухай Хорооны шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл холбогдогч этгээд шүүхэд гомдол гаргах эрхтэй.

94.2.Гомдол гаргасан нь Хороо, энэ хуульд заасан бусад эрх бүхий этгээдийн шийдвэр, үйл ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй.

94.3.Хадгаламж, зээлийн хоршоонд албадлагын арга хэмжээ авсан Хороо, бүрэн эрхт төлөөлөгч, тусгай төлөөлөгч, татан буулгах комиссын шийдвэр хууль бус, түүний улмаас гомдол гаргагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдсөн болохыг шүүхээс тогтоосон тохиолдолд уг шийдвэр, түүнд үндэслэн гарсан бусад шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх, түдгэлзүүлэх үндэслэл болохгүй бөгөөд зөвхөн нэхэмжлэгчид учирсан бодит хохирлыг мөнгөн хэлбэрээр холбогдох хуульд заасны дагуу гаргуулахаар шийдвэрлэнэ.

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД

95 дугаар зүйл. Мэдээллийн нууцлалыг хадгалах

95.1.Зохицуулах хороо болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтан нь энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараах этгээдтэй холбоотой аливаа мэдээллийг бусдад задруулахыг хориглоно:

95.1.1.тусгай зөвшөөрөл авахаар өргөдөл гаргасан этгээд;

95.1.2.хадгаламж, зээлийн хоршоо, түүний сонгуульт болон гүйцэтгэх албан тушаалтан;

95.1.3.хадгаламж, зээлийн хоршооны гишүүн.

95.2.Дараах тохиолдолд энэ хуулийн 94.1 дэх хэсэг хамаарахгүй:

95.2.1.тухайн этгээд өөрийн нууцыг задруулахыг бичгээр зөвшөөрсөн;

95.2.2.Хороо шаардсан;

95.2.3.шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажлын шаардлагаар тэдгээр байгууллагын удирдлага хүсэлт гаргасан, эсхүл авлигатай тэмцэх байгууллага, цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны шаардлагаар, түүнчлэн тагнуулын байгууллага мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон мэдээллийг шалгах шаардлагаар тэдгээрийн удирдлагын хүсэлтийг мөрдөгчийн саналыг прокурор зөвшөөрсөн;

95.2.4.энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор тухайн этгээд мэдэх шаардлагатай;

95.2.5.уг мэдээллийг олон нийт бусад эх сурвалжаас мэдэх боломжтой, эсхүл нэгэнт мэдээлэгдсэн;

95.2.6.тухайн мэдээлэлтэй холбогдох энэ хуулийн 95.1-д заасан этгээдийг таних боломжгүй байдлаар буюу мэдээллийг товчлол, эсхүл статистик тоо баримтаар мэдээлэх;

95.2.7.гадаадын зохицуулах байгууллага бичгээр хүсэлт гаргасан.

96 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

96.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

96.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

97 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

97.1.Энэ хуулийг 2020 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

97.2.Тогтворжилтын сантай холбоотой энэ хуулийн ... дугаар зүйлийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

97.3.Хадгаламжийн даатгалын сангаас нөхөн төлбөр олгохтой холбоотой энэ хуулийн ... дүгээр зүйлийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ